

БУЛГАН АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН

**Орон нутгийн хөгжлийн сангийн бүрдүүлэлт,
зарцуулалт, үр нөлөө, үр дүн**

АУДИТЫН КОД: БУА-2022/20-4/ШТА-ГА

БУЛГАН АЙМАГ
2022 ОН

Булган дахь Төрийн аудитын газрын дарга,
Тэргүүлэх аудитор Б.Эрдэнэ
Утас: 7034-2580 Цахим хаяг: Erdeneb@audit.gov.mn
Аудитын менежер: Ж.Энхцоодол
Утас: 7034-2716 Цахим хаяг: Enkhsaoodol@audit.gov.mn
Ахлах аудитор: Г.Намчинсүрэн
Утас: 7034-2495 Цахим хаяг: namchinsureng@audit.gov.mn
Аудитор: А.Сувдаа
Утас: 7034-2495 Цахим хаяг: Suvdaaa@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дараах хаягаар авна уу.
bulgan@audit.gov.mn

Товчилсон үгийн тайлбар

АДБОУБ	Аудитын дээд байгууллагын олон улсын байгууллага
АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
ГХБХБГ	Газарын харилцаа барилга хот байгуулалтын газар
ЗДТГ	Засаг даргын тамгын газар
ИНХ	Иргэдийн нийтийн хурал
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал
МУЕА	Монгол Улсын Ерөнхий аудитор
МУЗГ	Монгол улсын Засгийн газар
ОНХНС	Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сан
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
СТСХ	Санхүү төрийн сангийн хэлтэс
ТБОНӨХБАҮХАТХ	Төрийн болон орон нутгийн өмч хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль
ТЕЗ	Төсвийн ерөнхийлөн захирагч
ТТХ	Төсвийн тухай хууль
ТЭЗҮ	Техник эдийн засгийн үнэлгээ
ХБТХ	Хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтэс

Хүснэгтийн товъёг

№	Тайлбар	Хуудасны дугаар
Хүснэгт 1	Аймгийн ОНХС-гаас сумын аймаг, сумдын ОНХС-д олгосон шилжүүлэг	
Хүснэгт 2	Орон нутгийн хөгжлийн сангийн эх үүсвэрийн төлөвлөлт	
Хүснэгт 3	ОНХС-гийн хөрөнгөөр хэрэгжүүлэх хөрөнгө оруулалт, төсөл арга хэмжээнд санал өгсөн иргэдийн тоон үзүүлэлт	
Хүснэгт 4	Аймаг, суманд хэрэгжүүлсэн төсөл арга хэмжээг төлөвлөхтэй холбоотой зөрчлийн дүн	
Хүснэгт 5	ОНХС-гийн хөрөнгөөр санхүүжүүлсэн хөрөнгө оруулалт, төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааны тоон мэдээлэл	

Графикийн товъёг

№	Тайлбар	Хуудасны дугаар
График 1	Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн арга хэмжээний ангилал	
График 2	Орон нутгийн хөгжлийн сангийн төлөвлөлт, зарцуулалтын иргэдээс авсан санал асуулга	
График 3		

Хавсралтын товъёг

№	Тайлбар	Хуудасны дугаар
Хавсралт 1	Орон нутгийн хөгжлийн сангийн санхүүжилтийн хуваарь, санхүүжилтийн гүйцэтгэл	
Хавсралт 2	Орон нутгийн хөгжлийн сангийн санал асуулгын нэгтгэл	
Хавсралт 3	Аймаг, сумын Орон нутгийн хөгжлийн төлөвлөлт зарцуулалтыг удирдлага, мэдээллийн санд мэдээлсэн мэдээлэл	
Хавсралт 4		

Аудит хийх үндэслэл, бүрэн эрх	Аудитын зорилт, хамарсан хүрээ, стандарт, арга зүйн талаарх мэдэгдэл Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1-д заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Улсын Их хурлын Төсвийн байнгын хорооны 2021 оны 06 дугаар тогтоол, МУЕА-ын 2022 оны А/12 дугаар тушаалаар баталсан “Төрийн аудитын байгууллагын 2022 онд гүйцэтгэх аудитын төлөвлөгөө”-г үндэслэн хийлээ.
Аудитын зорилго	Орон нутгийн хөгжлийн сангийн бүрдүүлэлт, зарцуулалт, үр нөлөө, үр дүнд гүйцэтгэлийн аудит хийж, дүгнэлт гарган зөвлөмж боловсруулж, дүнг холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулахад аудитын зорилт чиглэгдлээ. Аудитын зорилгыг хангахын тулд аудитыг дараах дэд зорилтын хүрээнд гүйцэтгэнэ. Үүнд: - Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийг холбогдох хууль журамд заасны дагуу төлөвлөж, бүрдүүлж, хуваарилсан эсэх; - Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг журмын дагуу үр дүн, үр нөлөөтэй хэрэгжүүлсэн эсэх; - Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийн зарцуулалтыг хууль, журмын дагуу хянаж, тайлагнасан эсэх.
Аудитын хамарсан хүрээ	ОНХС-ийн 2021 оны орлого бүрдүүлэлт, хуваарилалт болон хэрэгжүүлсэн хөтөлбөр, төсөл, арга, хэмжээний төлөвлөлт, гүйцэтгэл, санхүүжилт, хяналт, тайлагнал болон аймгийн ХБТХ, СТСХ болон аймаг, сумын ИТХ, ЗДТГ, баг, хороодын ИНХ, Засаг даргын холбогдох үйл ажиллагааг хамруулан шалгалаа.
Аудитын арга зүй, шалгуур үзүүлэлт	Аудитыг АДБОУБ (INTOSAI)-ын Стандартын хорооноос баталсан АДБОУС-100, АДБОУС-300, АДБОУС-3000-д нийцүүлэн баталсан Монгол Улсын Төрийн аудитын стандарт MNS 6817-1:2020 “Төрийн аудит. Тулгуур зарчим”, MNS 6817-5:2020 “Төрийн аудит. Гүйцэтгэлийн аудитын тулгуур зарчим”, MNS 6817-7:2020 “Төрийн аудит. Гүйцэтгэлийн аудит”, MNS 6817-8:2020 “Төрийн аудит. Нийцлийн аудит”-ын стандартад заасан зарчим, арга зүйд нийцүүлэн, Монгол Улсын Ерөнхий аудиторов баталсан Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам (2020 он), Гүйцэтгэлийн аудитын заавар, аргачлал (2020 он)-ын дагуу холбогдох албан тушаалтнуудтай ярилцлага хийх, асуулга лавлагаа, тодруулга болон судалгаа авах, харьцуулах, нэгтгэх, дүн шинжилгээ хийх зэрэг арга зүйг ашиглан аудитын хөтөлбөр, горим, асуудлын шинжилгээний дагуу нотлох зүйл цуглуулж, аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж боловсрууллаа.

Аудитын бүрэлдэхүүн, хугацаа	Аудитыг Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Б.Эрдэнэ хянан удирдаж, менежер Ж.Энхцоодол үе шатны чанарын хяналтыг хийж, ахлах аудитор Г.Намчинсүрэн, аудитор А.Сувдаа нар хийж гүйцэтгэлээ.
Хүндрэл бэрхшээл:	Аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу 2022 оны 05 дугаар сарын 02-ны өдрөөс 2022 оны 06 дугаар сарын 03-ны өдөр хүртэл гүйцэтгэж, аудитын тайланг 2022 оны 06 дугаар сарын 05-ны өдөр Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт хүргүүлжээ. Байхгүй.
Үндсэн мэдээлэл:	Засгийн газрын 2017 оны 08 дугаар сарын 17-ны өдрийн “Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сан болон орон нутгийн хөгжлийн сангаас олгох орлогын шилжүүлгийг тооцох аргачлал батлах тухай” 230 дугаар тогтоол гарснаар Засгийн газрын 2012 оны 9 дүгээр сарын 15-ны өдрийн 30 дугаар тогтоолоор баталсан “Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийн орлогын шилжүүлгийг тооцох аргачлал”-ийг хүчингүй болгосон. Засгийн газрын 2017 оны 08 дугаар сарын 17-ны өдрийн “Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сан болон орон нутгийн хөгжлийн сангаас олгох орлогын шилжүүлгийг тооцох аргачлал батлах тухай” 230 дугаар тогтоол гарснаар Засгийн газрын 2012 оны 9 дүгээр сарын 15-ны өдрийн 30 дугаар тогтоолоор баталсан “Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийн орлогын шилжүүлгийг тооцох аргачлал”-ийг хүчингүй болгосон. Сангийн сайдын 2014 оны 43 дугаар, 2018 оны 228 дугаар тушаалаар баталсан “Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийг төлөвлөх, батлах, санхүүжүүлэх, хэрэгжүүлэх, бүртгэх, тайлагнах, хяналт тавих үйл ажиллагааны журам”-ыг мөрдөж байсан бөгөөд Сангийн сайдын 2021 оны 05 дугаар сарын 24-ний өдрийн 86 дугаар тушаалаар “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам”-ыг шинэчлэн баталжээ. Монгол Улсын 2021 оны Төсвийн тухай хуульд зааснаар ОНХНС болон улсын төсвөөс Булган аймгийн ОНХС-д олгох орлогын шилжүүлгийн хэмжээг 4060.7 сая төгрөгөөр баталсан ба 2021 оны 07 дугаар сарын 07-ны өдөр хуульд оруулсан нэмэлт өөрчлөлтөөр ОНХНС болон улсын төсвөөс Булган аймгийн ОНХС-д олгох орлогын шилжүүлгийн хэмжээг 183.5 сая төгрөгөөр нэмэгдүүлж 4,244.2 сая төгрөгөөр баталсан байна. Олон Улсын Хөгжлийн Ассоциаци болон Монгол Улсын Засгийн газар хооронд 2015 оны 01 дүгээр сарын 30-ны өдөр “Тогтвортой амьжиргаа 3” төслийг хэрэгжүүлэхээр Зээл №5487-MN тоот санхүүжилтийн хэлэлцээр хийсэн бөгөөд тус төсөл нь хөдөө орон нутагт тэргүүлэх ач холбогдол бүхий хөрөнгө оруулалтыг төлөвлөх, хэрэгжүүлэхэд иргэдийн оролцоо, засаглалыг сайжруулах зорилготой үйл ажиллагаа явуулж байна. Энэ хүрээнд Монгол Улсын 2021 оны төсвийн тухай хуулийн 4 дүгээр хавсралтаар Булган аймагт дээрх төслөөс 2021 онд 84.7 сая төгрөгийн дэмжлэг, 75.2 сая төгрөгийн урамшуулал олгохоор баталжээ.

БҮЛЭГ 1 ОРОН НУТГИЙН ХӨГЖЛИЙН САНГИЙН ЭХ ҮҮСВЭРИЙГ ХУУЛЬ, ЖУРАМД ЗААСАН ЭХ ҮҮСВЭРИЙГ БҮРЭН ТӨЛӨВЛӨӨГҮЙ, ОНХНС-гаас ОЛГОХ ШИЛЖҮҮЛГИЙГ БҮРЭН ХУВААРИЛСАН БАЙНА.

Аймгийн ОНХС-гаас болон улсын төсвөөс олгох шилжүүлгийг бүрэн олгосон ч батлагдсан хуваарийн дагуу санхүүжүүлээгүй, зарим сумд татварын хэмжээг нэмэгдүүлэх замаар бий болгосон нэмэгдэл эх үүсвэр, ОНХС-гийн харилцах дансны эхний үлдэгдлийг орон нутгийн хөгжлийн сангийн эх үүсвэрт нэмж төлөвлөөгүй байна.

1.1 Монгол Улсын төсвийн тухай хуулиар Булган аймгийн Орон нутгийн хөгжлийн санд олгох шилжүүлгийг 4,060.7 сая төгрөгөөр баталж 2021 оны 07 дугаар сарын төсвийн өөрчлөлтөөр 183.0 сая төгрөгөөр нэмэгдүүлж нийт 4,244.2 сая төгрөгөөр өөрчилсөн байна.

1.2 Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сан, улсын төсвөөс олгосон орлогын шилжүүлэг болон “Тогтвортой амьжиргаа-3” төслөөс хуваарилагдсан хөрөнгийг Төсвийн тухай хуулийн 59 дүгээр зүйлд заасны дагуу орон нутгийн суурь зардалд 534.2 сая, “Тогтвортой амьжиргаа-3” төслийн дэмжлэг, урамшуулал, нэр заагдсан ашигт малтмалын хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрлийн төлбөрийг хасаж, Төсвийн тухай хуулийн 59.2.2¹ дахь заалтын дагуу 1,337.5 сая төгрөгийг сумын хүн амын тоо, алслалт, нутаг дэвсгэрийн хэмжээг харгалзан сумдад, үлдэх 2,372.1 сая төгрөгийг аймгийн ОНХС-д хуваарилсан байна.

Хүснэгт № 1 Аймгийн ОНХС-аас сумын аймаг, сумдын ОНХС-д олгосон шилжүүлэг (сая.төг)

№	СУМ	Итгэлцүүрт үндэслэсэн хуваарилалтын дүн	ТА-3 төслийн дэмжлэг	ТА-3 төслийн урамшуулал	АМ-ын хайгуулын тусгай зөвшөөрлийн төлбөр	АМ-ын ашиглалтын тусгай зөвшөөрлийн төлбөр	Нийт суманд хуваарилагдсан дүн
1	Баян-Агт	46.40	5.28	19.04	0	0	70.72
2	Баяннуур	22.93	2.86	0	0	1.36	27.15
3	Бугат	28.99	3.28	0	0	0.76	33.03
4	Булган	51.03	6.94	0	0	0	57.97
5	Бүрэгхангай	38.19	4.32	0	31.40	79.94	153.85
6	Гурванбулаг	43.29	4.95	0	1.81	0.66	50.71
7	Дашинчилэн	40.50	4.68	17.85	0	4.85	67.87
8	Могод	36.84	4.38	0	0	0	41.23
9	Орхон	40.43	4.48	0	0	119.05	163.96
10	Рашаант	42.05	5.10	18.37	3.81	0	69.32
11	Сайхан	41.52	4.60	0	5.87	2.42	54.42
12	Сэлэнгэ	54.23	6.38	0	0	12.57	73.18
13	Тэшиг	86.28	9.61	0	0	12.06	107.94
14	Хангал	44.13	5.55	19.99	0	0	69.66
15	Хишиг-Өндөр	203.81	3.86	0	5.43	0.04	213.15
16	Хутаг-Өндөр	75.14	8.44	0	0	0	83.59
	НИЙТ ДҮН	895.75	84.70	75.25	48.33	233.72	1,337.75

1.3 Аймгийн Засаг даргын 2021 оны А/454 дүгээр захирамжаар аймаг, сумын ОНХС, аймгийн суурь зардалд олгох орлогын шилжүүлгийн сар, улирлын хуваарийг баталсан байна.

1.4 Харин сумдын ОНХС-ийн батлагдсан төсвийг Төсвийн тухай хуулийн 41.3-д заасны дагуу Төсвийн сарын хуваарийг Засаг даргын захирамжаар батлуулаагүй байна.Тухайлбал: Хутаг-Өндөр сум, Баяннуур сум, Гурванбулаг сум, Рашаант сум.

¹ энэ зүйлийн 59.2.1-д зааснаас бусад хэсгийн 50-аас доошгүй хувийг хүн амын тоо, алслалт, нутаг дэвсгэрийн хэмжээг харгалзан хуваарилах;

1.5 Аймгийн ОНХС-гаас олгох санхүүжилтийг баталсан хуваарийн дагуу шилжүүлгийг 3-6 саруудад 240.3 сая төгрөгөөр дутуу санхүүжүүлж 7, 8,10 саруудад нөхөж шилжүүлсэн нь ОНХС-гийн орлогын эх үүсвэр Сангийн яаманд хоцорч төвлөрсөнтэй холбоотойгоор сумдын ОНХС-гийн хөрөнгийг хуваарийн дагуу шилжүүлээгүй нь Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.4², 41.2.5³ дахь заалтуудыг тус тус зөрчихөд хүргэсэн байна. (Хавсралт-1)

1.6 Энэ нь ОНХС-гаас санхүүжүүлж байгаа хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл арга хэмжээний санхүүжилт хойшилсноос шалтгаалж зарим төсөл арга хэмжээ батлагдсан хугацаанд бүрэн хэрэгжихгүй байх эрсдэл үүссэн байна.

1.7 Иймд төсвийн тухай хуулийн дагуу төсөвт төвлөрөх орлогын төлөвлөгөөг биелүүлэх, орлогыг бодтой төлөвлөх, мөн сумдын ТЭЗ нар Төсвийн тухай хуульд заасны дагуу төсвийн сарын хуваарийг Засаг даргын захирамжаар батлуулах шаардлагатай байна.

Зарим сумд татварын хэмжээг нэмэгдүүлэх замаар бий болгосон нэмэгдэл эх үүсвэр, ОНХС-гийн харилцах дансны эхний үлдэгдлийг орон нутгийн хөгжлийн сангийн эх үүсвэрт нэмж төлөвлөөгүй байна.

1.8 Аймаг, сум нь Төсвийн тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.2⁴ болон Засгийн газрын 2017 оны 230 дугаар тогтоолоор баталсан “Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сан болон Орон нутгийн хөгжлийн сангаас олгох орлогын шилжүүлгийг тооцох аргачлал”-ын 2.2-т заасны дагуу аймаг, сумдын ОНХС-гийн эх үүсвэр 6 төрлийн орлогоос бүрдэхээр заасан байна.

Хүснэгт №2 Орон нутгийн хөгжлийн сангийн эх үүсвэрийн төлөвлөлт (сая.төг)

Эх үүсвэр	Дүн	Хувийн жин
Өмнөх оны үлдэгдэл	415.5	6.46
ОНХС болон улсын төсвөөс олгосон шилжүүлэг	4,084.30	63.48
Тогтвортой амьжиргаа -3 төсөл	159.9	2.49
ТТХ-ийн 60.2.4 Татварын хувь хэмжээг нэмэгдүүлэх болон зарлагыг хэмнэх замаар бий болгосон эх үүсвэр	546.7	8.50
Бусад орлого	1,228.00	19.08
Нийт дүн	6,434.40	100.00

1.9 Дор дурдсан сумд ОНХС-гийн эх үүсвэрийг хууль, журамд заасан зарим нэр төрөл болон бусад эх үүсвэрээр нэмэгдүүлсэн байна.Тухайлбал:

- Орон нутгийн давсан орлогоос Бугат сум 7.5, Булган сум 16.6, Могод сум 15.0, Тэшиг 74.6, Дашинчилэн 14.5,
- Бүрэгхангай сум уул уурхайн аж ахуй нэгжүүдийн нийгмийн хариуцлагын гэрээний дагуу хандив 1100.0,
- Татварын хувь хэмжээг нэмэгдүүлэх буюу малын хөлийн татварын орлогоос Рашаант сум 122.5, Орхон сум 131.0, Бүрэгхангай сум 168.0, Хангал сум 30.0, Могод сум 95.2,
- ОНХС-гийн харилцах дансны эхний үлдэгдлээс аймгийн ОНХС 1.6, Баян-Агт сум 4.3, Бугат сум 53.1, Булган сум 10.6, Бүрэгхангай сум 131.8, Гурванбулаг сум 64.7, Дашинчилэн сум 31.6, Могод сум 2.3, Рашаант сум 3.2, Сайхан сум 19.5, Тэшиг сум 29.3, Хангал сум 13.7, Хишиг-Өндөр сум 13.8 сая төгрөгөөр тус тус нэмэгдүүлсэн байна. (Судалгааны хүснэгт-1)

1.10 Зарим сумд ОНХС-ийн эх үүсвэрийг төлөвлөхдөө Төсвийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.8⁵, 60 дугаар зүйлийн 60.2.4⁶ дахь заалтаар ОНХС-ийн эх үүсвэрт малын тоо толгойн албан татварын орлого болон бусад эх үүсвэрээс орлого бүрдэх боломжтой

² төсвийн сар, улирлын хуваарийг баримталж ажиллах;

³ энэ хуулийн 37.1.8-д заасан эрхийн хүрээнд төсвийн байгууллагын зардлыг санхүүжүүлэх;

⁴ Орон нутгийн хөгжлийн сан нь дараах эх үүсвэрээс бүрдэнэ:

⁵ Сум, дүүргийн төсвийн татварын орлого дараах орлогоос бүрдэнэ

⁶ татварын хувь хэмжээг нэмэгдүүлэх болон зарлагыг хэмнэх замаар бий болгосон нэмэгдэл эх үүсвэр;

байхад төлөвлөгөөнд тусгаагүй зөвхөн ОНХС-гаас олгох орлогын шилжүүлгээр төлөвлөж сумын ИТХ-аар батлуулсан байна.

1.11 Энэ нь ОНХС-гийн эх үүсвэрийг дутуу тооцоолох, сангийн хөрөнгө иргэдийн саналгүйгээр зориулалт бусаар зарцуулагдах эрсдэлтэй байна.

1.12 Сумдын хэмжээнд 2021 онд Төсвийн тухай хуулийн дээрх заалтын дагуу орон нутгийн ерөнхий орлогын дансанд нийт 1,553.1 сая төгрөгийн малын хөлийн татварын орлого төвлөрснөөс Орхон сум (8.0 сая), Рашаант сум (56.9 сая) сумдаас бусад сум ОНХС-гийн харилцах дансанд тухайн эх үүсвэрийг төвлөрүүлээгүй зөрчилд 1,439.4 сая төгрөгийн албан шаардлагыг хүргүүлээ.

1.13 Мөн Тогтвортой амьжиргаа-3 төслийн урамшуулал авах нөхцөл хангасан Баян-Агт, Булган, Гурванбулаг, Дашинчилэн, Рашаант, Сайхан зэрэг сумд 12.0-18.5 сая төгрөгийн урамшуулал авч эх үүсвэрийг нэмэгдүүлж бусад сум урамшууллаар ОНХС-гийн эх үүсвэрийг нэмэгдүүлэх боломжийг алдсан байна.

1.14 Иймд ОНХС-гийн эх үүсвэрийг орлогын эх үүсвэр тус бүрээр төлөвлөх, бүрдүүлэхэд сумдын төсвийн төвлөрүүлэн захирагч нар идэвх санаачилгатай ажиллах шаардлагатай байна.

ОНХС-гийн хөрөнгөөр хэрэгжүүлэх хөтөлбөр, төсөл, арга хэмжээг төлөвлөхдөө холбогдох журам зааврыг бүрэн хэрэгжүүлэн ажиллаагүй байна.

1.15 Төсвийн тухай хуулийн 63 дугаар зүйлийн 63.1⁷, 63.2⁸, “Орон нутгийн төсвийн төсөл боловсруулах журам”-ын 12⁹ дугаар зүйлд ОНХС-гийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөхдөө иргэдээс санал авч урьдчилсан жагсаалт бэлтгэн олон нийтээр хэлэлцүүлж, нийтийн эрх ашигт нийцсэн нэгдсэн жагсаалтыг ИТХ-д өргөн мэдүүлэхээр заасан.

1.16 Аймаг, сумын хэмжээнд ОНХС-гийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл арга хэмжээнд сонгууль өгөх насны 89546 иргэдээс 24467 иргэн буюу 27.3 хувь нь хамрагдан санал өгсөн байна.

Хүснэгт №3 ОНХС-гийн хөрөнгөөр хэрэгжүүлэх хөрөнгө оруулалт, төсөл арга хэмжээнд санал өгсөн иргэдийн тоон үзүүлэлт

№	Аймаг, сум	Санал өгөх иргэдийн тоо	Нийт санал өгсөн иргэдийн тоо	Санал өгсөн иргэдийн хувь
1	2	3	4	5
1	Аймаг	44,773	14,335	32.0
2	Сумд	44,773	10,132	22.6
Нийт дүн		89,546	24,467	27.3

1.17 Дээрх хүснэгтээс үзэхэд ОНХС-гийн хөрөнгөөр хэрэгжүүлэх хөрөнгө оруулалт, төсөл, арга хэмжээнд иргэдийн саналыг авах ажил хангалтгүй, иргэдийг санал өгөх хүртээмжтэй байдлаар зохион байгуулаагүй, сургалт сурталчилгаа соён гэгээрүүлэх ажлыг үр дүн муутай зохион байгуулсантай холбоотой байна.

1.18 Аудитын явцад иргэд олон нийтээс авсан Орон нутгийн хөгжлийн сангийн талаар хэр мэдээлэлтэй гэсэн санал асуулгад судалгаанд оролцсон иргэдийн 351 буюу 62.7 хувь нь хангалтгүй гэж хариулсан нь дээрх дүгнэлттэй уялдаж байна. (Хавсралт-2)

1.19 Иргэд олон нийтийн ОНХС-гийн талаарх мэдээ, мэдээлэл дутмагаас ОНХС-гийн үндсэн зорилго биелэхгүй, хэрэгжүүлэх төсөл арга хэмжээнд санал өгч байгаа иргэдийн санал хязгаарлагдмал байгаагаас батлагдсан хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээ үр өгөөжгүй, хэрэгцээ багатай болсон байна.

⁷ “Баг, хорооны Засаг дарга ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээ, тэдгээрийг хэрэгжүүлэх дараалал, арга замын талаар баг, хороодод олон нийтийн нээлттэй санал асуулга явуулна”,

⁸ “Энэ хуулийн 63.1-д заасан санал болон баг, хорооны ИНХ дээр гарсан саналыг ИНХ хэлэлцэн, тэргүүлэх ач холбогдол бүхий төсөл, арга хэмжээг эрэмбэлэн сонгоно”

⁹ тухайн шатны Засаг дарга ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөхдөө иргэдээс санал авч урьдчилсан жагсаалт бэлтгэн олон нийтээр хэлэлцүүлж, нийтийн эрх ашигт нийцсэн нэгдсэн жагсаалтыг ИТХ-д өргөн мэдүүлэхээр заасан.

1.20 Сангийн сайдын 2018 оны 09 дүгээр сарын 12-ны өдрийн 228 дугаар тушаалаар баталсан “Орон нутгийн хөгжлийн сангийн заавар”-ын 3.1.1,¹⁰, 4.1¹¹, Сангийн сайдын 2012 оны 11 дүгээр сарын 19 өдрийн 244 дүгээр тушаалын 6.3.4¹² дэх заалтуудад ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээ нь улсын хөрөнгө оруулалтын дунд хугацааны хөтөлбөр, УИХ, МУЗГ болон тухайн орон нутгаас хөгжлийн талаар баримталж байгаа бодлого стратеги, орон нутгийн дунд хугацааны төлөвлөлттэй уялдсан байхаар тусгасан байна.

1.21 Цаашид ОНХС-д иргэдийн оролцох оролцоог нэмэгдүүлж, хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл арга хэмжээг төлөвлөж хэвших шаардлагатай байна.

ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг сумдын хэмжээнд орон нутгийн хөгжлийн бодлого, тэргүүлэх чиглэлтэй уялдуулан төлөвлөсөн байна.

1.22 Сангийн сайдын 2018 оны 09 дүгээр сарын 12-ны өдрийн 228 дугаар тушаалаар баталсан “Орон нутгийн хөгжлийн сангийн заавар”-ын 3.1.1,¹³, 4.1¹⁴, Сангийн сайдын 2012 оны 11 дүгээр сарын 19 өдрийн 244 дүгээр тушаалын 6.3.4¹⁵ дэх заалтуудад ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээ нь улсын хөрөнгө оруулалтын дунд хугацааны хөтөлбөр, УИХ, МУЗГ болон тухайн орон нутгаас хөгжлийн талаар баримталж байгаа бодлого стратеги, орон нутгийн дунд хугацааны төлөвлөлттэй уялдсан байхаар тусгасан байна.

1.23 Аймгийн ОНХС-гийн хөгжлийн бодлогын тэргүүлэх чиглэл болон газар зохион байгуулалтын төлөвлөгөөтэй уялдсан байдал, хасагдах хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээ байгаа эсэх, хөрөнгө оруулалтын урьдчилан тооцсон төсөвт өртгийг үр өгөөж хүртэгчдийн тоонд харьцуулан төслийн төсөвт өртгийн харьцаанд ажлын хэсэг дүн шинжилгээ хийлгүйгээр иргэдийн санал хамгийн их авсан ажлыг баталсан байна. Тухайлбал:

- Аймгийн ОНХС-гийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл хөтөлбөр, арга хэмжээг орон нутгийн хөгжлийн бодлого, тэргүүлэх чиглэлтэй уялдаагүй хөтөлбөр, төсөл арга хэмжээг баталж хэрэгжүүлсэн, саналын урьдчилсан жагсаалт бэлтгэсэн эсэх нь тодорхойгүй, зарим төсвийн шууд захирагчдаас ирүүлсэн санал, зөвхөн иргэдийн санал авсан жагсаалтаас өөр анхан шатны баримт материал байхгүй байна

1.24 Сумдын түвшинд орон нутгийн хөгжлийн бодлого, тэргүүлэх чиглэлтэй уялдуулан ОНХС-гийн хөрөнгөөр хэрэгжүүлэх хөрөнгө, оруулалт, төсөл арга хэмжээг төлөвлөсөн байна.

1.25 Аудитаар илэрсэн дээрх зөрчилд холбогдох хуулийн заалтыг бүрэн хэрэгжүүлэх зөвлөмжийг хүргүүллээ.

1.26 Сумын урсгал зардал, зам арчилгаа, засвар, нийтийн эзэмшлийн гэрэлтүүлэг, нийгмийн хариуцлагын гэрээ, хүүхдийн тоглоомын талбайг тохижуулах тасал арга хэмжээг хэрэгжүүлсэн нь Төсвийн тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.11¹⁶, Сангийн сайдын 2018 оны 228 дугаар тушаалын 4 дүгээр зүйлийн 4.2.3¹⁷, Сангийн сайдын 2021 оны 86 дугаар

¹⁰ ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээ нь Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан урт, дунд болон богино хугацааны хөгжлийн бодлогын баримт бичгүүдтэй уялдсан байх;

¹¹ Аймаг, нийслэл, сум, дүүрэг нь ОНХС-ийн хөрөнгөөр Төсвийн тухай хуулийн 58 дугаарзүйлд заасан чиг үүрэгт хамаарах энэ журмын 4.2-т зааснаас бусад хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний хүрээнд барилга байгууламж барих, тоног төхөөрөмж худалдан авах, их засвар хийх ажлыг санхүүжүүлнэ.

¹² орон нутгийн дунд хугацааны төлөвлөлттэй уялдсан байх

¹³ ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээ нь Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан урт, дунд болон богино хугацааны хөгжлийн бодлогын баримт бичгүүдтэй уялдсан байх;

¹⁴ Аймаг, нийслэл, сум, дүүрэг нь ОНХС-ийн хөрөнгөөр Төсвийн тухай хуулийн 58 дугаарзүйлд заасан чиг үүрэгт хамаарах энэ журмын 4.2-т зааснаас бусад хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний хүрээнд барилга байгууламж барих, тоног төхөөрөмж худалдан авах, их засвар хийх ажлыг санхүүжүүлнэ.

¹⁵ орон нутгийн дунд хугацааны төлөвлөлттэй уялдсан байх

¹⁶ Энэ хуулийн 60.3.6 дахь заалтад 58.1.8, 58.1.12, 58.2.11, 58.2.12, 58.2.15, 58.3.4, 58.4.3, 58.4.4, 58.4.9, 58.4.10-т заасныг хэрэгжүүлэхтэй холбогдсон үйлчилгээний зардал хамаарахгүй.

¹⁷ Орчны тохижилт, ногоон байгууламж, байгаль орчныг хамгаалах;

тушаалын 4 дүгээр 4.6.3¹⁸-т заасныг зөрчсөн Баян-Агт сум 3, Могод сум 3, Хангал сум 1, Бүрэгхангай сум 4 төсөл арга хэмжээг хэрэгжүүлэн ажилласан зөрчилд албан шаардлага хүргүүлээ.

ОНХС-ийн хөрөнгөөр иргэдийн санал аваагүй, зураг төсөвгүй ТЭЗҮ-гүй төсөл, арга хэмжээг баталж, хэрэгжүүлдэг зөрчил давтан гарсан байна.

1.27 Аймаг, сумын ИТХ нь Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3¹⁹, 29 дүгээр зүйлийн 29.4²⁰, Сангийн сайдын 2018 оны 228 дугаар тушаалаар баталсан “Орон нутгийн хөгжлийн сангийн заавар”-ын 3.1.2²¹, 3.1.3²² “Орон нутгийн төсвийн төсөл боловсруулах журам”-ын 6.3²³ дахь заалтуудын дагуу төлөвлөхөөр заажээ.

1.28 ОНХС-гийн хөрөнгөөр хэрэгжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээг төлөвлөх, иргэд, олон нийтийн оролцоог хангахдаа саналын хуудсаар нээлттэй санал асуулга авах, иргэдийн саналыг эрэмбэлж тухайн шатны ИТХ-д өргөн мэдүүлэх ажлыг хийж хэвшсэн боловч хэрэгжүүлэх төсөл, хөтөлбөр арга хэмжээг төлөвлөхдөө дээр дурдсан хууль, журмын шалгуур үзүүлэлтийг баримтлаагүй зураг төсөвгүй, ТЭЗҮ-гүй, шаардагдах хөрөнгө, төсөвт өртгийг тооцоогүй төсөл, арга хэмжээг баталж, хэрэгжүүлсэн нь ОНХС-ийн хөрөнгийн үр өгөөжийг бууруулж, орон нутагт үр ашиггүй хөрөнгө нэмэгдэх эрсдэлийг нэмэгдүүлж байна.

Хүснэгт № 4 Аймаг, суманд хэрэгжүүлсэн төсөл арга хэмжээг төлөвлөхтэй холбоотой зөрчлийн дүн

(сая.төг)

Д/д	Аймаг,сумд ын нэрс	Батлагдсан төсөл, арга хэмжээ		Иргэдийн санал аваагүй төсөл арга хэмжээ		ТЭЗҮ, зураг, төсөвгүй		Нийт дүн		Батлагдс ан төсөвт зөрчлийн эзлэх хувь
				Гүйцэтгэлийн аудитаар илэрсэн зөрчил						
		тоо	Төсөвт өртөг	тоо	Төсөвт өртөг	тоо	Төсөвт өртөг	тоо	Төсөвт өртөг	
1	Аймаг	10	1,740.6	3	523.4			3	523.4	30
2	Тэшиг	4	226.8	1	18.5			1	18.5	25
3	Хутаг-Өндөр	4	99.6	1	15.6			1	15.6	25
4	Баяннуур	9	61.5	1	2.7			1	2.7	11
5	Хялганат	7	41.3			1	38.0	1	38.0	14
6	Бүрэгхангай	8	1,282.7		1,158.4		1,158.4	-	2,316.8	-
	Нийт дүн	42	3,452.5	6	1,718.6	1	1,196.4	7	2,915.0	17
Санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн зөрчил										
7	Баяннуур	9	61.5			9	61.2	9	61.2	100
8	Гурванбулаг	3	138.6			2	23.0	2	23.0	67
9	Дашинчилэн	12	106.1			11	81.1	11	81.1	92
10	Орхон	14	224.2			7	207.1	7	207.1	50
11	Хишиг-Өндөр	6	63.1			6	58.1	6	58.1	100
12	Рашаант	16	207.8			15	137.8	15	137.8	94
13	Хангал	6	55.0			6	55.0	6	55.0	100
14	Баян-Агт	16	81.9			16	81.9	16	81.9	100
15	Могод	11	161.9			11	161.9	11	161.9	100
	Нийт дүн	93	1,100.1	-	-	83	867.1	83	867.1	89
	Бүгд нийт дүн	135	4,552.6	6	1,718.6	84	2,063.5	90	3,782.1	67

¹⁸ Төсвийн тухай хуулийн 58.1.8, 58.1.12, 58.2.11, 58.2.12, 58.2.15, 58.3.4, 58.4.3, 58.4.4, 58.4.9, 58.4.10-т заасан төрлийн үйлчилгээний зардал.

¹⁹ өөрийн эрхлэх асуудлын хүрээнд төсвийг үр ашигтай удирдах, гүйцэтгэлийг хангах;

²⁰ Хөрөнгө оруулалтын төсөвт техник, эдийн засгийн үндэслэл хийгдсэн, зураг төсвөө батлуулсан, хуульд заасан бусад зөвшөөрөл олгогдсон төсөл, арга хэмжээг тусгана.

²¹ ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээ нь тухайн орон нутгийн иргэдийн саналаар дэмжигдэж эрэмбэлэгдсэн байх;

²² ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээ нь хуульд заасны дагуу зураг төсөв, техник, эдийн засгийн үндэслэлтэй, байгаль орчны төлөв байдлын үнэлгээ хийгдсэн, бусад холбогдох зөвшөөрөлтэй байх;

²³ хөрөнгө, оруулалтын төсөл хөтөлбөр арга хэмжээ нь хуульд заасны дагуу техник, эдийн засгийн үндэслэл хийгдсэн, зураг төсөв нь батлагдсан, байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ хийгдсэн, бусад зөвшөөрөлтэй байх;

1.29 Дээрхээс үзэхэд зөрчил гаргасан аймаг, сумд нийт ОНХС-гийн хөрөнгөөр хэрэгжүүлэхээр төлөвлөсөн төсөл арга хэмжээний 67 хувь буюу 3,782.1 сая төгрөгийг иргэдийн санал аваагүй, ТЭЗҮ-гүй, шаардагдах хөрөнгө, төсөвт өртгийг тооцоогүй төсөл, арга хэмжээг баталж, хэрэгжүүлсэн байна.

1.30 Нийт зөрчилд эзлэх мөнгөн дүнгийн нийт 61.2 хувь буюу 2,316.8 сая төгрөг нь Бүрэгхангай сумын нийгмийн хариуцлагын гэрээгээр ОНХС-гийн хөрөнгийн эх үүсвэрийг нэмэгдүүлж иргэдийн санал аваагүй, ТЭЗҮ-гүй нэг багц дүнгээр төлөвлөсөн хөрөнгө оруулалт төсөл арга хэмжээ байна.

1.31 Сумдын түвшинд ОНХС-гийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөхдөө зураг, төсөвгүй ажлыг төлөвлөж байгаа нь зураг төсвийг урьдчилж хийлгэхэд тухайн төсөл, арга хэмжээ ИТХ-аар батлагдахгүй байх, мөн зураг төсөв хийлгэх өртөг өндрөөс тухайн суманд хуваарилагдсан хөрөнгийн ихэнх хувь нь зарцуулагдах, эх үүсвэр хүрэлцдэггүй гэсэн шалтгаантай холбоотой байна.

1.32 Эдгээр шалтгаанаас үүдэн ихэвчлэн хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг ИТХ-аар батлуулсны дараа ТЭЗҮ, зураг, төсвийг төсөвт өртөгт багтаан хийдэг, бага төсөвт өртөгтэй ажлын төсөвт өртөг, тооцооллыг хийхгүй багц дүнгээр батлуулдаг нийтлэг зөрчил байна.

1.33 Мөн аймаг, сумдын хэмжээнд ИТХ-ын тэргүүлэгчид иргэдийн санал аваагүй, орон нутгийн хөгжлийн бодлого төлөвлөлтэй уялдаагүй төсөл, арга хэмжээг баталдагтай холбоотой байна.

1.34 Дээрх илэрсэн зөрчлийг цаашид давтан гаргахгүй байх, таслан зогсоох, холбогдох дүрэм журмыг бүрэн хэрэгжүүлэн ажиллах нийт 1809.4 сая төгрөгийн 10 албан шаардлага хүргүүлээ.

1.35 Санхүүгийн тайлангийн аудитаар дээрх зөрчилтэй холбоотой нийт 1,114.4 сая төгрөгийн зөрчлийн таслан зогсоох, холбогдох хууль тогтоомжийг бүрэн хэрэгжүүлэн ажиллах албан шаардлага хүргүүлсэн.

БҮЛЭГ 2

ОРОН НУТГИЙН ХӨГЖЛИЙН САНГИЙН ХӨРӨНГӨӨР ХЭРЭГЖҮҮЛЭХ ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭГ ЖУРМЫН ДАГУУ БҮРЭН ҮР ДҮН, ҮР НӨЛӨӨТЭЙ ХЭРЭГЖҮҮЛЭЭГҮЙ БАЙНА.

Аймаг, сумын ЗДТГ нь ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлсэн хөтөлбөр, төсөл арга хэмжээг хэрэгжүүлэхдээ холбогдох хууль тогтоомжийг бүрэн баримтлаагүй, хэрэгжүүлсэн нийт төсөл арга хэмжээний 21.7 хувь нь худалдан авах ажиллагааны хууль, журмыг зөрчсөн байна.

2.1 Аймгийн хэмжээнд 2021 онд нийт 4,843.9 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 156 хөрөнгө оруулалт, төсөл хөтөлбөр, арга хэмжээг худалдан авах ажиллагаа зохион байгуулахаар төлөвлөгдсөнөөс гүйцэтгэл 73 хувьтай бөгөөд 860.0 сая төгрөгийн 43 төсөл арга хэмжээ хэрэгжээгүй байна. Нийт 3,943.0 сая төгрөгийн 129 төсөл арга хэмжээнд худалдан авах арга хэмжээг зохион байгуулсан байна.

Хүснэгт № 5 ОНХС-гийн хөрөнгөөр санхүүжүүлсэн хөрөнгө оруулалт, төсөл, арга, хэмээний худалдан авах ажиллагааны тоон мэдээлэл

/сая.төг/

Д/д	Үзүүлэлт	Худалдан авах ажиллагааны журам							
		Нээлттэй тендер шалгаруулалт		Харьцуулалтын арга		Шууд гэрээ байгуулах		Олон нийтийн оролцоотой	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Аймаг ОНХС	3	780	3	130	4	830.6		
2	Сумд ОНХС	2	267.3	11	433.9	122	1,049.1	3	28
3	Нийт дүн	5	1,047.3	14	563.9	126	1,879.7	3	28

2.2 **Аймаг:** Аймгийн ОНХС-гийн хөрөнгөөр хэрэгжүүлэхээр төлөвлөсөн нийт 10 хөрөнгө оруулалт, төсөл хөтөлбөр, арга хэмжээний 30 хувь буюу 3 ажлыг нээлттэй тендер шалгаруулалтын журмаар, 30 хувь буюу 3 ажлыг тендер шалгаруулалтын харьцуулалтын журмаар, 40 хувь буюу 4 ажлыг шууд гэрээ байгуулан худалдан авсан байна.

2.3 Аймгийн Засаг даргын захирамжаар томилогдсон зарим үнэлгээний хороо, ажлын хэсгүүд ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, хөтөлбөрийн гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах ажиллагааг зохион байгуулахдаа ТБОНӨХБАҮХАТХ-ийн 7 дугаар зүйлийн 7.1²⁴, 7.2²⁵, 29 дүгээр зүйлийн 29.1²⁶ дахь заалтыг тус тус зөрчсөн нь ОНХС-гийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн хөрөнгө оруулалт, төсөл хөтөлбөр үр дүнгүй, үр өгөөжгүй ажилд зарцуулагдах эрсдэлтэй байна. Тухайлбал:

- Өвс, тэжээлийн нөөц бүрдүүлэх 150.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 2 ажилд тендер сонгон шалгаруулалт зарлаагүй шууд гэрээ байгуулсан.
- Булган аймгийн Эрүүл мэндийн газарт тоног төхөөрөмж худалдан авч өгөх 30.6 сая төгрөгийн өртөгтэй ажилд тендер зарлаагүй шууд нэмэлт санхүүжилтийн данс руу шилжүүлж түргэвчилсэн оношлуур, хяналтын монитор, хүчилтөрөгч өтгөрүүлэгч авсан.
- Аймгийн ЗДТГ-ын үйлчилгээний автомашиныг худалдан авах ТББ-ийг боловсруулахдаа ТБОНӨХБАҮХАТХ-ийн 11.1.3²⁷, 11.1.4²⁸ дэх заалтыг зөрчсөн, сонгон шалгаруулахдаа дээрх хуулийн 29.1²⁹ дэх заалтыг зөрчин хамгийн бага үнийн санал ирүүлсэн ХХК-ийг сонгоогүй байна.
- Сургуулийн автобус сонгон шалгаруулах Үнэлгээний хорооны хурлын тэмдэглэл, шийдвэрт тендер оролцогчийн нэр зөрүүтэй зэрэг зөрчлүүд илэрсэн.

2.4 **Сум:** Сумдын ОНХС-гийн хөрөнгөөр хэрэгжүүлэхээр төлөвлөсөн нийт 119 хөрөнгө оруулалт, төсөл хөтөлбөр, арга хэмжээний 1.6 хувь буюу 2 ажлыг нээлттэй тендер шалгаруулалтын журмаар, 9.2 хувь буюу 11 ажлыг тендер шалгаруулалтын харьцуулалтын журмаар, 2.5 хувь буюу 3 ажлыг олон нийтийн оролцоотой худалдан авах ажиллагааны журмаар, 86.5 хувь буюу 103 ажлыг шууд худалдан авсан байна.

2.5 Сумдын түвшинд сумын засаг даргын захирамжаар байгуулсан ажлын хэсэг нь ТБОНӨХБАҮХАТХ-ийн 7 дугаар зүйлийн 7.1³⁰, 7.2³¹, 8 дугаар зүйлийн 8.2³², 50 дугаар зүйлийн 50.1.4³³, заалтыг зөрчсөн байна. Тухайлбал:

- Нийгмийн хариуцлагын гэрээгээр нийт 527.8 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 22 хөрөнгө оруулалт, төсөл, арга хэмжээг шууд гэрээ байгуулан гүйцэтгүүлсэн. (Бүрэгхангай сум)
- “Оч” цэцэрлэгийн хашааг засварлах 12.9 сая төгрөгийн төсөвт өртөгтэй ажлыг гүйцэтгүүлэхдээ үйл ажиллагааны чиглэл өөр компаниар гүйцэтгүүлсэн, соёлын төвийн тоног төхөөрөмжийг хоёр компаниас худалдаж авсан. (Могод сум)

²⁴ Захиалагч бараа, ажил, үйлчилгээ худалдан авахдаа дор дурдсан тендер шалгаруулалтын журмыг баримтлан гүйцэтгэгчийг сонгож гэрээ байгуулна:...

²⁵ Хуульд энэ хуулийн 7.1.2-7.1.4-т заасан журмыг хэрэглэхээр зааснаас бусад тохиолдолд нээлттэй тендер шалгаруулалтын журмыг мөрдөнө.

²⁶ Захиалагч энэ хуулийн 27 дугаар зүйлд заасан шаардлага хангасан, 28 дугаар зүйлд зааснаар “хамгийн сайн” үнэлэгдсэн тендер ирүүлсэн оролцогчид гэрээ байгуулах эрх олгохоор шийдвэрлэж, энэ тухай түүнд болон бусад тендер оролцогч бүрт шалгараагүй үндэслэлийн хамт нэгэн зэрэг бичгээр мэдэгдэнэ;

²⁷ барааны тэмдэг, нэр, хэлбэр маяг, төрөл, гарал үүсэл, үйлдвэрлэлийн арга, үйлдвэрлэгч буюу нийлүүлэгчийг тухайлан заасан шаардлага, нөхцөл тавихгүй;

²⁸ энэ хуулийн 11.1.3-т заасан шаардлага, нөхцөлийг заах шаардлагатай бол түүний ард “эсхүл түүнтэй дүйцэх” гэсэн тодотгол хэрэглэх.

²⁹ Захиалагч энэ хуулийн 27 дугаар зүйлд заасан шаардлага хангасан, 28 дугаар зүйлд зааснаар “хамгийн сайн” үнэлэгдсэн тендер ирүүлсэн оролцогчид гэрээ байгуулах эрх олгохоор шийдвэрлэж, энэ тухай түүнд болон бусад тендер оролцогч бүрт шалгараагүй үндэслэлийн хамт нэгэн зэрэг бичгээр мэдэгдэнэ.

³⁰ Захиалагч бараа, ажил, үйлчилгээ худалдан авахдаа дор дурдсан тендер шалгаруулалтын журмыг баримтлан гүйцэтгэгчийг сонгож гэрээ байгуулна:...

³¹ Хуульд энэ хуулийн 7.1.2-7.1.4-т заасан журмыг хэрэглэхээр зааснаас бусад тохиолдолд нээлттэй тендер шалгаруулалтын журмыг мөрдөнө.

³² Энэ хуулийн 8.1.1-д заасан босго үнээс дээш төсөвт өртөгтэй бараа, ажил, үйлчилгээг худалдан авахад энэ хуульд өөрөөр заагаагүй бол нээлттэй тендер шалгаруулалтын журмыг хэрэглэнэ

³³ “тендер оролцогч гэр бүлийнх нь гишүүн, эсхүл тендер оролцогч хуулийн этгээдэд гэр бүлийнх нь гишүүн ажилладаг буюу цалин хөлс авдаг зэрэг сонирхлын зөрчил үүсгэж болзошгүй нөхцөл байвал өөрийн шууд харьяалан удирдах албан тушаалтанд мэдэгдэж, тухайн тендер шалгаруулалтыг зохион байгуулах ажиллагаанд оролцохгүй байх.

- Ногоон байгууламжийг нэмэгдүүлэх, Наран хороонд хүүхдийн тоглоомын талбай байгуулах, Хүүхдийн тоглоомын талбай тохижуулах нийт 22.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 3 төсөл, арга хэмжээг гүйцэтгэхдээ материалыг өөрсдөө бэлтгэн ажлын хөлсийг олгосон.(Дашинчилэн сум)
- Наадмын талбайн тохижилт, нийтийн эзэмшлийн талбайн тохижилт засварлах 24.9 сая төгрөгийн төсөл арга хэмжээг тус тус 2 гүйцэтгэгч байгууллагаар гүйцэтгүүлсэн.(Хангал сум)
- Сумын төвийн гэрэлтүүлгийн 8.6 сая төгрөгийн ажлыг гүйцэтгүүлэхдээ Иргэдийн төлөөлөгч бүл байгуулж 2 хөтөлбөр, төсөл арга хэмжээний гэрэлтүүлгийн ажлыг гүйцэтгэсэн. (Хялганат тосгон)
- Хангал сумын Хялганат тосгоны Багийн ИНХ дарга 20.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй гэрэлтүүлэг хийх 3 төсөл арга хэмжээг "Гэрэлт Хялганат" иргэдийн бүлэг байгуулан гэрээ байгуулан хэрэгжүүлсэн. (Хангал сум)
- ЭМТ-ийн багаж тоног төхөөрөмжийн хүлээж авсан акт байхгүй, Соёлын төвийн 19.6 сая төгрөгийн төсөвтэй тоног төхөөрөмжийг худалдан авах техникийн тодорхойлолт байхгүй(Могод сум)
- Наадмын талбайн тохижилт, нийтийн эзэмшлийн талбайн тохижилт засварын 25.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй үйлчилгээний төсөл арга хэмжээг тус тус 2 гүйцэтгэгч байгууллагаар гүйцэтгүүлсэн. (Хангал сум)

2.6 Аудитаар илэрсэн дээрх зөрчлүүдэд холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцлага тооцох, зөрчлийг таслан зогсоох албан шаардлага, хууль тогтоомжийг бүрэн хэрэгжүүлэн ажиллах зөвлөмжийг хүргүүлээ.

ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх боломжтой чиг үүргээс бусад төсөл, арга хэмжээнд сангийн хөрөнгийг зарцуулсан байна.

2.7 Төсвийн тухай хуулийн 58 дугаар зүйл³⁴, 60 дугаар зүйлийн 60.11 “Орон нутгийн хөгжлийн сангийн заавар”-ын дөрөвт аймаг, сум-ын ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх чиг үүргийг тодорхойлсон байна.

2.8 ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх хөтөлбөр, төсөл арга хэмжээнд зарцуулах төсвийн хувь хэмжээг зааглаагүй, хөтөлбөр, төсөл арга хэмжээний нэршлийг тодорхой тусгаагүйгээс сангийн хөрөнгийг хөтөлбөр, төсөл арга хэмжээ нэрээр зориулалт бус, нийтийн эрх ашигт нийцээгүй үйл ажиллагаанд зарцуулан, урсгал зардлуудыг санхүүжүүлж тус сангийн үр нөлөөг бууруулах, үр ашиггүй зардал гарах нөхцөлийг бүрдүүлсэн нь Төсвийн тухай хуулийн 60.3.³⁵, Сангийн сайдын 2021 оны 86 дугаар тушаалын “Орон нутгийн хөгжлийн сангийн заавар”-ын 3.4.1³⁶, 4.6³⁷, 4.7.3³⁸, 4.7.6³⁹ дэх заалтыг тус тус зөрчсөн байна.

Аймгийн хэмжээнд:

- Аймгийн ЗДТГ-ын нийтлэг үйлчилгээний албанд 48.3 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 2 авто машин худалдан авахад зарцуулсан

Сумын хэмжээнд:

- Хогны машины жолоочид 5.8, олон нийтийн цагдаад 4.7 сая төгрөгийн цалинг ИТХ-аар баталж олгосон. (Баян-Агт)
- Нийгмийн хариуцлагын гэрээний хавсралтаар нийт 18 ажил хийгдэхээс 2021 онд санхүүжүүлсэн 527.7 сая төгрөгийн 22 төсөл, арга хэмжээнээс 3 төсөл хөтөлбөр, арга хэмжээнд 264.6 сая төгрөгийг зарцуулж нийгмийн хариуцлагын гэрээнд

³⁴ Орон нутгийн чиг үүргийг санхүүжүүлэх

³⁵ Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийг дараах зүйлд зарцуулахыг хориглоно:

³⁶ ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжих хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний жагсаалтыг хууль, журмын дагуу боловсруулан бэлтгэж тухайн шатны ИТХ-аар хэлэлцүүлэн батлуулах;

³⁷ ОНХС-ийн хөрөнгийг зөвхөн дараах хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээнд зарцуулах ба өөр бусад зорилгоор зарцуулахгүй;

³⁸ нийтийн эрх ашигт нийцээгүй үйл ажиллагаа,

³⁹ Аливаа аж ахуйн нэгж, байгууллага, иргэнд олгох буцалтгүй тусламж, дэжлэг, тэтгэмж, урамшуулал

тусгагдаагүй 263.0 сая төгрөгийн 19 төсөл, хөтөлбөр арга хэмжээг хэрэгжүүлсэн байна.(Бүрэгхангай сум)

- Шагнал урамшуулалд 0.9 сая төгрөгийг олгосон (Тэшиг сум)
- Хогийн цэгийн байршлыг өөрчилж шинэ цэг байгуулах 7.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй ажлын зураг төсөв, ажлын гэрээ, ажлыг хүлээн авсан акт байхгүй, санхүүжилтийг бэлнээр авсан боловч хэнд өгсөн тодорхойгүй анхан шатны баримтаар нотлогдоогүй.(Хялганат тосгон)
- Хуучин хогийн цэгийг дарж булах 8.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй ажлын 2.0 сая төгрөгийн ажлын хөлсийг өөр эх үүсвэрээр давхардуулан санхүүжүүлсэн. (Хялганат тосгон)

2.9 ОНХС-гийн хөрөнгөөр хэрэгжүүлэхээр батлагдсан хөрөнгө оруулалт төсөл арга хэмжээний хөрөнгийг зарцуулахтай холбоотойгоор бусад хууль тогтоомж зөрчсөн, гэрээний үүргээ биелүүлээгүй зөрчлүүд илэрлээ. Тухайлбал:

- Барьцаа хөрөнгийн дансанд гэрээ сунгасан Спорт заалны барилгын санхүүжилтийг 33.4 сая төгрөгөөр илүү, мөн 1.0 сая төгрөгийн алдангийг төвлөрүүлсэн.(Аймаг)
- Сумын гадна усан хангамж, ариутгах татуургын шугам дагалдах барилга байгууламжийн угсралтын ажлын нэгдсэн төсвийг шинэчлүүлэх зураг төсөв, "Шинэ суурьшлын бүсийн цахилгаан хангамжийн дэд станц"-ын зураг төсвийг гэрээний хугацаанд нь биелүүлээгүй. (Дашинчилэн сум)
- Урсдаг самбар, камер засварлах ажлыг хүлээж авсан акт байхгүй, соёлын төвийн тайзны гэрэлтүүлэг болон дээврийн засварыг гэрээний хугацаанд дуусгаагүй, он дамжуулж хүлээж авсан, зам даваа засварлах ажлын гэрээнд 2022 онд хийгдэхээр тусгасан ажлын санхүүжилтийг олгосон, гүйцэтгэсэн ажлыг хүлээж авсан актгүй нийт 15.8 сая төгрөгийг зарцуулсан. (Баян-Агт сум)
- ЗДТГ-ын засварын ажлын зураг төсвийн санхүүжилт 10.0 сая төгрөгийг зарцуулсан боловч авлагаар тусгаагүй. (Хутаг-Өндөр сум)
- Баяннуур сумын 80 айлын орон сууцны зураг төсвийг одоог хүртэл хүлээж аваагүй, үлдэгдэл санхүүжилт 13.5 сая төгрөгийг барьцаа хөрөнгийн дансанд байршуулсан.

2.10 Засаг даргын зөвлөлийн санал болгож эрэмбэлсэн ажил дээр ИТХ хяналт тавихгүй баталсан нь ОНХС-гийн чиг үүрэгт хамаарахгүй бусад байгууллагын урсгал зардал, ойрын хэрэгцээ шаардлагыг хангах зардалд зарцуулж байгаа нь зориулалт бус зарцуулах үндэслэл болсон байна.

2.11 Аудитаар илэрсэн дээрх зөрчлүүдэд 11.4 сая төгрөгийн төлбөрийн акт, 331.6 сая төгрөгийн зөрчлийг таслан зогсоох албан шаардлага, 48.3 сая төгрөгийн холбогдох хууль тогтоомжийг бүрэн хэрэгжүүлэн ажиллах зөвлөмжийг хүргүүлээ.

ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээ төлөвлөсөн зорилтот түвшин, үр ашиг, үр дүнг бодитой тодорхойлоогүй байна.

2.12 Аймаг, сумдын хэмжээнд Тэшиг сумаас бусад ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл арга хэмжээг төлөвлөхдөө Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1⁴⁰, 14 дүгээр зүйлийн 14.2.3⁴¹, 14.3⁴², өөрийн эрхлэх асуудлын хүрээнд төсвийг үр ашигтай удирдах, гүйцэтгэлийг хангах, Сангийн сайдын Сангийн сайдын 2021 оны 86 дугаар тушаалаар баталсан "Орон нутгийн төсвийн төсөл боловсруулах журам"-ын 7.3.4⁴³ дахь заалтын дагуу хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээ төлөвлөсөн зорилтод түвшин үр дүнг бодитой тодорхойлоогүй, хөрөнгө оруулалтын урьдчилан тооцсон төсөвт өртгийг үр өгөөж хүртэгчдийн тоонд харьцуулсан төслийн төсөвт өртгийн харьцааг тооцсон тоо мэдээлэл байхгүй, тодорхойлсон гэх боловч холбогдох хангалттай зохистой нотлох баримт байхгүй байна.

⁴⁰ төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах,

⁴¹ өөрийн эрхлэх асуудлын хүрээнд төсвийг үр ашигтай удирдах, гүйцэтгэлийг хангах;

⁴² Төсвийн ерөнхийлөн захирагч өөрийн эрхлэх асуудлын төсвийн орлого, зарлагын зүй зохистой, үр ашигтай байдал, үр дүнгийн гүйцэтгэлийг хангаж, өөрт хамаарах төсвийн гүйцэтгэлийн биелэлтийг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засгийн газар, Улсын Их Хурлын өмнө бүрэн хариуцна.

⁴³ Хөрөнгө оруулалтын урьдчилан тооцсон төсөвт өртгийг үр өгөөж хүртэгчдийн тоонд харьцуулсан харьцаа.

2.13 ОНХС-гийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, хөтөлбөр арга хэмжээний үр дүнтэй, үр ашигтай байдалд анхаарлаа хандуулаагүй, ОНХС-ийн ажлын хэсэг байгуулдаггүй, мөн холбогдох хууль тогтоомж, журамд заасан байгууллага хяналтын чиг үүргийг бүрэн хэрэгжүүлээгүйтэй холбоотой байна. Тухайлбал:

- Дашинчилэн, Бүрэгхангай Сайхан, Сэлэнгэ сумын ИТХ холбогдох журамд заасан хяналтыг чиг үүргээ огт хэрэгжүүлээгүй.
- Баян-Агт сум, Могод сумын ИТХ-аас хяналтын чиг үүргийг хэрэгжүүлсэн боловч гаргасан шийдвэр тодорхой бус, мөн зөвлөмжийн биелэлтийг тооцож ажиллаагүй байна

2.14 Энэ нь орон нутгийн хөгжлийн хөрөнгөөр хэрэгжүүлж буй хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл арга хэмжээ нь сум, орон нутгийн хөгжилд үр дүн үзүүлээгүй байх эрсдэлтэй байна.


2.15 Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хийгдэж буй хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл арга хэмжээний зорилтот түвшин, үр ашиг, үр дүнг бодитоор төлөвлөж, хэрэгжилтийг тооцож, жилийн гүйцэтгэлийн үнэлгээтэй уялдуулан дүгнэж ажиллах зөвлөмжийг хүргүүллээ.

Сумдын хэмжээнд ОНХС-гийн хөрөнгийг богино хугацааны хэрэгцээ шаардлага хангах зардалд зарцуулж байна.

2.16 Сангийн сайдын 2021 оны 05 дугаар сарын 24-ний өдрийн 86 дугаар тушаалаар баталсан “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журмын” 1.4-т “ОНХС-ийн зорилго нь орон нутгийн хөгжлийг дэмжих, бүс нутгийн хөгжлийн тэнцвэртэй байдлыг хангах, иргэд тогтвор суурьшилтай амьдрах орчин, нөхцөлийг бүрдүүлэхэд чиглэгдэнэ гэж заажээ.

2.17 Дээрх зорилгыг хэрэгжүүлэхийн тулд нийт 172 хөрөнгө, оруулалт, төсөл арга хэмжээг төлөвлөснөөс 129 төсөл арга хэмжээг хэрэгжүүлэн 43 буюу нийт хөрөнгө оруулалт, төсөл, арга хэмжээний 33.8 хувь нь огт хэрэгжээгүй байна.

График-1 Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн арга хэмжээний ангилал



2.18 Хэдийгээр жил бүр хэрэгжүүлэхээр төлөвлөсөн хөрөнгө оруулалт, төсөл арга хэмжээний хэрэгжилт өндөр гардаг тоон мэдээлэл байгаа боловч аймаг, сумдын хэмжээнд ОНХС-гийн хөрөнгөөр хэрэгжүүлэх хөрөнгө оруулалт, төсөл арга хэмжээг төлөвлөхдөө Сангийн сайдын баталсан "Орон нутгийн төсвийн төсөл боловсруулах журам"-ын 7.3.4-д

заасны дагуу үр ашиг, үр өгөөжийг тооцох ажлыг орхигдуулдаг, үүнтэй холбоотойгоор хэрэгжүүлсэн хөрөнгө оруулалт төсөл арга хэмжээний үр дүн, хүрсэн үр дүн, үр өгөөжийг тооцож дүгнэлт хийдэггүйгээс орон нутгийн хөгжилд бодит үр дүн үзүүлж байгаа эсэхэд тоон үзүүлэлтийн хувьд дүгнэлт өгөх боломж бүрдээгүй байна.

2.19 Сумдын хувьд ОНХС-гийн хөрөнгийг орон нутгийн хөгжил эдийн засгийн ач холбогдол бүхий хөрөнгө оруулалтад бус, богино хугацааны хэрэгцээ, шаардлага хангах, олон жижиг арга хэмжээ буюу нийгмийн үр ашигтай байдал талаасаа учир дутагдалтай, захиргааны үйл ажиллагааг дэмжих, хүүхдийн тоглоомын талбай тохижуулах, хашаажуулах, дэд хөтөлбөр хэрэгжүүлэх, цэцэрлэг, сургууль, соёлын төвийн сургалтын хэрэглэгдэхүүн, золбин нохой устгах зэрэг ажлаас хэтрэхгүй байна.



Баян-Агт сумын ЕБС-ийн кабнет тохижуулалт

Баяннуур сумын хүүхдийн
ТалбайНогоон байгууламжийн
тохижуулалт, хашааМогод сум
Соёлын төвийн тоног төхөөрөмжРашаант сум
Шинэ дотуур байрны гал тогоонд
ширээ сандалСайхан сум
Золбин нохой устгал

2.20 Энэ нь сангийн удирдлага, зохион байгуулалтыг хэрэгжүүлж ажиллах эрх, үүрэг хүлээсэн албан тушаалтнууд үйл ажиллагаандаа сангийн хууль тогтоомжийг мөрдөж ажиллахгүйгээс сангийн зорилго, зорилт бүрэн биелэгдэхгүй жижиг төсөл, арга хэмжээг төлөвлөж байгаатай холбоотой байна.

2.21 Аудитын явцад иргэд олон нийтээс авсан дараах 2 санал асуулгад хариулсан байдлыг авч үзвэл:

График-2



2.22 Нийт санал асуулгад оролцсон иргэдийн 65.5 хувь нь хэрэгжүүлж буй бүтээн байгуулалтад хяналт тавьдаггүй, бүтээн байгуулалтын ажлуудын сэтгэл ханамж 33.8 хувь нь мэдэхгүй, 37 хувь нь хангалтгүй гэж хариулсан нь иргэд ОНХС-гийн хөрөнгөөр

хэрэгжүүлж буй төсөл арга хэмжээнд төдийлөн хяналт тавьж ач холбогдол өгдөггүй, мөн хэрэгжүүлсэн төсөл арга хэмжээ үр дүнгүй, иргэд олон нийт мэдээлэл хангалттай хүрдэггүй гэж дүгнэхээр байна.

2.23 Иймд ОНХС-ийн төлөвлөлтийг сайжруулж иргэдээс нийгмийн хувьд үр өгөөжтэй санал гаргах сэдлийг бий болгох, хөрөнгө оруулалтын ач холбогдлыг сурталчлан таниулах арга хэмжээг санаачлан хэрэгжүүлэх шаардлагатай байна.

Аймгийн ОНХС-гийн хөрөнгөөр бэлтгэсэн зарим хөрөнгийг ашиглаагүй, үр өгөөжийг иргэд олон нийт хүртээгүй үр ашигт шинж чанар нь алдагдсан, хадгалалт, хамгаалалт хангалтгүй байна.

2.24 Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 67 дугаар зүйлийн 1⁴⁴, 2⁴⁵, 77 дугаар зүйлийн 2⁴⁶-д, Орон нутгийн хөгжлийн сангийн заавар"-ын 9.12⁴⁷-д заасны дагуу орон нутгийн өмчийн хөрөнгийг эзэмших, ашиглах, захиран зарцуулах эрхээ хэрэгжүүлэх талаар зохиосон ажил, үр ашгийн тайлан, нэгдсэн тооллогын дүнг жил бүр хэлэлцэж, дүгнэлт, чиглэл өгөхийг ИТХ-д, өмч хөрөнгийн хадгалалт, хамгаалалтад бүртгэлээр тавих хяналт шалгалтыг хуулийн этгээдийн ерөнхий нягтлан бодогчид хариуцуулсан байна.

2.25 Аймгийн хэмжээнд ОНХС-гийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн хөрөнгө оруулалт, төсөл хөтөлбөрийн үр дүнд бий болсон хөрөнгийг захиалагч байгууллагын өмчлөлд бүртгэн авч тухайн байгууллага нь ашиглалт, хамгаалалтын зардлыг хариуцаж байна.

2.26 Аудитаар сумдад хэрэгжүүлсэн хөрөнгө оруулалт, хөрөнгийг ашиглагч байгууллагаас түүвэрлэн чанар байдлын ашиглалтын талаарх ярилцлага тайлбар тодруулга авахад ашиглалт, хамгаалалт хэвийн, чанартай холбоотой санал гомдол гараагүй. (Судалгааны хүснэгт-3)

2.27 Аймаг сумдын ИТХ, Засаг дарга ОНХС-гийн хөрөнгөөр санхүүжүүлсэн хөрөнгийн ашиглалт, хамгаалалт хэвийн эсэхэд хяналт шалгалт хийж, үнэлэлт дүгнэлт өгөөгүй, өмч хөрөнгийн хадгалалт, хамгаалалтад бүртгэлээр тавих хяналт сулаас зарим бэлтгэсэн хөрөнгийг ашиглаагүй, иргэд олон нийтийн хэрэгцээ шаардлагыг хангаагүй хөрөнгө бэлтгэсэн, хадгалалт хамгаалалт хангалтгүй байна.



Булган аймгийн нөөцийн газарт хадгалагдаж буй өвс, тэжээл

2.28 Аймгийн ОНХС-гаас 51.2 сая төгрөгөөр тэжээлийн нөөц, 95.0 сая төгрөгөөр өвс бэлтгэсэн боловч малчдын хэрэгцээ шаардлагыг хангаагүй тэжээл худалдан авч төсвийн хөрөнгийг үр ашиггүй зарцуулсан, өвс тэжээлийг одоог хүртэл зарцуулаагүй, ашиглалт, хангалтгүй байгаа нь ОНХС-гийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн төсөл хөтөлбөр үр өгөөжөө өгөөгүй, өвс, тэжээлийг стандартын дагуу хадгалаагүй, өвсийг ил задгай хашаанд өрсөн, тэжээлийг хадгалж байгаа агуулах стандартын бус асарч задарсан хадгалалт, хамгаалалт хангалтгүй байгаа нь цаашид тухайн хөрөнгийг ашиглах боломжгүй, төсвийн хөрөнгийг үр ашиггүй зарцуулах эрсдэл үүсж байна.

⁴⁴ Төрийн өмчит хуулийн этгээдийн эрх баригч нь өмч хөрөнгийн хадгалалт, хамгаалалтын байдалд өдөр тутам тавих дотоодын хяналтыг зохион байгуулж, түүний үр дүнг төрийн өмнө хариуцна.

⁴⁵ Өмч хөрөнгийн хадгалалт, хамгаалалтад бүртгэлээр тавих хяналт шалгалтыг тухайн хуулийн этгээдийн ерөнхий нягтлан бодогч хариуцна.

⁴⁶ Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг даргаас орон нутгийн өмчийн хөрөнгийг эзэмших, ашиглах, захиран зарцуулах эрхээ хэрэгжүүлэх талаар зохиосон ажил, үр ашгийн тайлан, нэгдсэн тооллогын дүнг жил бүр хэлэлцэж, дүгнэлт, чиглэл өгөх;

⁴⁷ ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн хөрөнгө оруулалтын үр дүнд бий болсон барилга байгууламж, тоног төхөөрөмж эд хөрөнгийг хуульд заасны дагуу өмчлөлд бүртгэж авсан байгууллага нь ашиглалт хамгаалалтын зардлыг хариуцна.

2.29 Аудитаар илэрсэн зөрчилд хөрөнгийн ашиглалт хамгаалалтыг сайжруулах ажлыг зохион байгуулах албан шаардлагыг хүргүүлсэн, иргэдийн хэрэгцээ шаардлагад нийцээгүй тэжээлийн шинж байдал, найрлагад шинжилгээ хийлгэх албан тоотыг аймгийн Мэргэжилийн хяналтын газарт хүргүүлээ.

БҮЛЭГ 3 ОНХС-ИЙН ХӨРӨНГӨӨР САНХҮҮЖҮҮЛСЭН ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭНИЙ ХЭРЭГЖИЛТЭД ТАВИХ ХЯНАЛТ ХАНГАЛТГҮЙ БАЙНА.

Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийн төлөвлөлт, хэрэгжилтэд тавих бүх шатны ИТХ-ын хяналт хангалтгүй байна.

3.1 **Аймгийн түвшинд:** Аймгийн ИТХ жил бүр сумдын ОНХС-гийн гүйцэтгэлд Санхүүгийн хяналт, аудитын албатай хамтран хяналт шалгалт хийдэг боловч аймгийн ОНХС-гийн төлөвлөлт, зарцуулалт хяналт шалгалтыг хийгээгүй Сангийн сайдын 2021 оны 05 дугаар сарын 24-ны өдрийн 86 дугаар тушаалаар баталсан “ОНХС-гийн үйл ажиллагааны журам”-ын 3.2.2⁴⁸ дахь заалтыг бүрэн хэрэгжүүлж ажиллаагүй байна.

3.2 Мөн дээрх журмын 9.4⁴⁹-д дурдагдсан байгууллагууд ОНХС-гийн хөрөнгөөр санхүүжүүлэх хөрөнгө оруулалт, төсөл, арга хэмжээний төлөвлөлт, санхүүжилт, зарцуулалт, гүйцэтгэл, тайлагналт, бүртгэл болон журмын хэрэгжилтэд хууль тогтоомжид заасан чиг үүргийн дагуу хяналт тавиагүй байна. Тухайлбал:

- Санхүүгийн хяналт, аудитын алба нь ОНХС-ийн 2021 оны зарцуулалтад тусгайлсан хяналт, шалгалт хийгээгүй байна.
- Аймгийн ЗДТГ-ын Хяналт шинжилгээ, үнэлгээ дотоод аудитын хэлтсээс 2021 оны ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлсэн хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл арга хэмжээнд хяналт шинжилгээ үнэлгээ хийгээгүй байна.
- Хөгжлийн бодлогын хэлтэс ОНХС-ийн хөрөнгөөр хийгдэж байгаа төсөл, арга хэмжээний хэрэгжилтийн жилийн эцсийн тайланд дүн шинжилгээ хийж, үнэлэлт, дүгнэлт өгч, цаашид хэрэгжүүлэх санал, зөвлөмжийн биелэлтийн талаар сумдын Засаг дарга, ОНХС хариуцсан ажилтан нарт үүрэг өгч ажиллаагүй нь ОНХС-ийн зааврын 10.1.1⁵⁰, 10.2.2⁵¹ дахь заалтыг бүрэн хэрэгжүүлэн ажиллаагүй байна.

3.3 **Сумдын түвшинд:** Бугат сум, Тэшиг сум, Хутаг-Өндөр сум, Хангал сум, Баян-Агт сум, Могод сумаас бусад сумдын ИТХ-ын хяналтын хороо ОНХС-гийн төлөвлөлт зарцуулалтад хяналт шалгалт хийгээгүй байна.

3.4 Цаашид ОНХС-ын үйл ажиллагааны журамд заасан чиг үүргээ хэрэгжүүлж ажиллахыг аймаг, сумдын ИТХ, аймгийн ЗДТГ-ын Хяналт шинжилгээ, үнэлгээ дотоод аудитын хэлтэст зөвлөмжийг хүргүүлээ.

Сумдын түвшинд захиалагчийн хяналтыг хууль, журмын дагуу бүрэн хэрэгжүүлэн ажиллаагүй байна.

3.5 ТБОНӨХБАҮХАТХ-ийн 46 дугаар зүйлийн 46.1.6⁵²-д захиалагч нь бараа, ажил, үйлчилгээг худалдан авах гэрээний үүргийн биелэлтэд хяналт тавихаар эрх үүргийг хуульчилсан.

⁴⁸ Тухайн шатны ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжиж буй хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний хэрэгжилтэд хяналт тавих;

⁴⁹ ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний төлөвлөлт, санхүүжилт, зарцуулалт, гүйцэтгэл, тайлагналт, бүртгэл болон энэ журмын хэрэгжилтэд төв, орон нутгийн хууль, хяналт, дотоод ба хөндлөнгийн аудитын байгууллага, аймаг, нийслэл, сум, дүүргийн ИТХ-ын дэргэдэх хороо болон иргэд, иргэний нийгмийн байгууллагууд Төрийн аудитын тухай хууль, Төрийн хяналт шалгалтын тухай хууль, Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль, Төсвийн тухай хууль, Засгийн газрын 2015 оны “Дүрэм батлах тухай” 483 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Дотоод аудитын дүрэм” болон эдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжид заасан чиг үүргийн дагуу хяналт тавина.

⁵⁰ УМС-ийн аюулгүй байдал, өгөгдлийн сан, систем байршиж буй сервер, сүлжээ, мэдээлэл татах, вэб сервисийн хэвийн ажиллагааг төрийн захиргаа удирдлагын асуудал хариуцсан нэгж;

⁵¹ УМС-ийн дотоод үйл ажиллагаа болон систем ашиглалт, заавар зөвлөгөө, системийн хэрэглэгчдийн бүртгэл, өөрчлөлтийг төсвийн бодлого, төлөвлөлтийн асуудал хариуцсан нэгж

⁵² гүйцэтгэгчийн гэрээний үүргийн биелэлтэд чанар болон гүйцэтгэлийн хяналт тавьж, явцын мэдээллийг хагас жил тутам худалдан авах ажиллагааны цахим системд оруулах

3.6 Аймгийн ОНХС-гийн хөрөнгөөр хийгдэж буй барилгын засварын ажил, шинээр баригдаж байгаа буй хөрөнгө оруулалтын ажилд захиалагчийн хяналтыг ГХБХБГ үе шатны ажлуудад хяналт тавьж ажлын гүйцэтгэлийг баталгаажуулснаар санхүүжилтийг олгож байна.

3.7 Сумдын хэмжээнд шууд гэрээ байгуулан гүйцэтгэх ажлуудад зураг, төсөв ТЭЗҮ-гүй ажлуудыг батлан хэрэгжүүлдэг, төсөл хөтөлбөр арга хэмжээг зохион байгуулах ажлын хэсэг томилогдсон зарим ажлын даалгаврыг боловсруулахдаа ажлын хэсэг захиалагчийн хяналт огт тавихгүй, тавьсан эсэх нь тодорхойгүй, холбогдох материал байхгүй байгаа нь ажлын чанарт сөргөөр нөлөөлөх, томоохон төсөвт өртөгтэй ажлын хувьд зохиогчийн хяналтыг хийлгээгүйгээс гүйцэтгэгч байгууллага зураг төсөвт тусгагдсан ажлыг бүрэн гүйцэтгээгүй байхад санхүүжилтийг бүрэн олгох эрсдэлтэй байна.

3.8 Мөн зарим хэрэгжүүлсэн хөрөнгө оруулалтын ажлыг гүйцэтгүүлэхдээ зураг төсөвт тусгагдсан захиалгын хяналтын зардал, магадалшгүй ажлын зардал, зохиогчийн хяналтын зардлыг гүйцэтгэгч байгууллагад шилжүүлсэн, шууд гэрээгээр ажил гүйцэтгүүлэхдээ захиалагч байгууллага өөрсдөө тухайн ажлыг гүйцэтгэх түүхий эд материалыг бэлтгэн зөвхөн ажлыг гүйцэтгэх хөлсийг олгох гэрээ байгуулж санхүүжилтийг олгосон байна.Тухайлбал:

- ЗДТГ-ын гадна засварын ажлыг гүйцэтгүүлэхдээ захиалагчийн техникийн хяналтын зардал, зураг төсөв зохиогчийн хяналтын зардлыг 0.5 сая төгрөгийг шилжүүлсэн /Бүрэгхангай сум/
- ЕБС-ийн дотуур байрны өргөтгөлийн барилгын ажилд техникийн хяналт, магадалшгүй ажлын зардал 19.3 сая төгрөгийг гүйцэтгэгч байгууллагад олгосон. /Бүрэгхангай сум/
- Ногоон байгууламжийг нэмэгдүүлэх, наран хороонд хүүхдийн тоглоомын талбай байгуулах, хүүхдийн тоглоомын талбай тохижуулах 3 төсөл, арга хэмжээг гүйцэтгэхдээ материалыг захиалагч байгууллага өөрсдөө бэлтгэж ажлын хөлсийг олгосон./Дашинчилэн сум/

3.9 Аудитаар илрүүлсэн дээрх зөрчилд нийт 19.8 сая төгрөгийг төсөвт төвлөрүүлэх төлбөрийн акт тогтоож хүргүүллээ.

3.10 Цаашид сумдын түвшинд томоохон хэмжээний хөрөнгө оруулалтын ажилд захиалагчийн хяналтыг мэргэжлийн байгууллагатай гэрээ байгуулан захиалагчийн хяналтыг үр дүнтэй хэрэгжүүлэх шаардлагатай байна.

Өмнөх оны аудитаар өгөгдсөн акт, албан шаардлагыг 100 хувь, зөвлөмжийг 66.6 хувийг хэрэгжүүлж ажилласан байна.

3.11 ОНХС-гийн 2019 оны хөрөнгийн зарцуулалт, үр дүнд хийсэн нийцлийн аудитаар төлбөрийн акт 3, албан шаардлага 4, аймгийн Засаг даргад 3 зөвлөмж хүргүүлснээс төлбөрийн актын биелэлт 100 хувь, албан шаардлагын биелэлт 100 хувь, зөвлөмжийг 66.6 хувь тус тус хэрэгжүүлсэн байна.

3.12 ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний төлөвлөлт, санхүүжилт, зарцуулалт, гүйцэтгэл, тайлагналт, бүртгэлийн явцад хяналт, шинжилгээ үнэлгээг ОНХС-ийн үйл ажиллагааны журмын 9.5-д заасан захиргааны байгууллагаар хийлгэх гэсэн зөвлөмж бүрэн хэрэгжээгүй байна.

3.13 “ОНХС-гийн үйл ажиллагааны журам”-ын 3.2.2-д заасны дагуу Хутаг-Өндөр, Бугат, Тэшиг, Хангал, Баян-Агт, Могод сумдын ИТХ-ын хяналтын хороо орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр санхүүжүүлсэн хөтөлбөр, арга хэмжээ, хөрөнгө оруулалтын ажлын гүйцэтгэл, ажлын даалгаварт хяналтыг хэрэгжүүлж хөтөлбөр арга хэмжээг эрчимжүүлэх, ажлыг сайжруулах, ОНХС-гийн хяналтын зөвлөл, ИТХ-ын төсөв санхүүгийн хурлыг

хороонд ажлын гүйцэтгэл, чанарт хяналт тавьж ажиллах нийт 17 зөвлөмжийг хүргүүлэн ажилласан боловч хэрэгжилтийг тооцож ажиллаагүй байна.

3.14 Цаашид ОНХС-аас хэрэгжүүлж буй хөтөлбөр төсөл арга хэмжээнд тавих хяналтыг тогтмолжуулж, холбогдох байгууллагад өгсөн чиглэл, үүргийн биелэлтийг тооцож шийдвэрийн биелэлтийг хангуулж ажиллах тал дээр бүх шатны ИТХ, Санхүүгийн хяналт, аудитын алба, ХБХХ хяналт тавих чиг үүргээ бүрэн хэрэгжүүлэн ажиллах шаардлагатай байна.

Сумдын Засаг даргын Тамгын газар ОНХС-гийн хөрөнгөөр санхүүжиж буй хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний хэрэгжилтийн тайланд мэдээллийг бүрэн тусгаагүй тайлагнасан байна.

3.15 Сангийн сайдын 2021 оны 05 дугаар сарын 24-ний өдрийн 86 дугаар тушаалаар баталсан “ОНХС-гийн үйл ажиллагааны журам”-ын 9.2-д “Сум, дүүргийн Засаг даргын Тамгын газрын дарга нь ОНХС-гийн хөрөнгөөр санхүүжиж буй хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний хэрэгжилтийн тайланг гаргаж дараа оны 2 дугаар сарын 01-ний өдрийн дотор аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө, оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтэст хүргүүлэх...” гэж заажээ.

3.16 Аймгийн ХОХБТХ нь ОНХС-гийн хэрэгжилтийн жилийн эцсийн тайланг нэгтгэж, жил бүрийн 3 дугаар сарын 10-ны өдрийн дотор санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлж тус журмын 9.9-д заасныг мөн хэрэгжүүлж ажилласан байна.

3.17 Сумдын Засаг даргын Тамгын газрын дарга нь ОНХС-гийн хөрөнгөөр санхүүжиж буй хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний хэрэгжилтийн тайланг аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө, оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтэст хүргүүлсэн боловч журамд заагдсан ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлсэн арга хэмжээг журам зааврын дагуу шинээр бий болсон барилга байгууламж, гүйцэтгэсэн их засварын ажил, нийлүүлэгдсэн тоног төхөөрөмжийг өмчлөлд бүртгэснийг баталгаажуулсан баримт, сайн туршлага, жишээ оновчтой санал зэргийг тусгаагүй байна.

3.18 Иймд аймгийн Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтэс нь сумдын Засаг даргаас ирүүлж байгаа ОНХС-гийн хөрөнгөөр санхүүжсэн хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний хэрэгжилтийн тайланг холбогдох журамд заасан мэдээллийг бүрэн багтаасан тайланг ирүүлэх чиглэл зааврыг хүргүүлэх зөвлөмжийг хүргүүллээ.

3.19 ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлсэн арга хэмжээг санхүүгийн тайланд журам, зааврын дагуу тайлагнаагүй байна. Орон нутгийн хөгжлийн сангийн гүйлгээг бүртгэхдээ цаг хугацааны дараалал болон арга хэмжээг санхүүжүүлсэн ажил гүйлгээ бүрээр журналд бүртгэхгүй бөөн дүнгээр нь дансны бичилт хийж бүртгэсэн зөрчилд 2021 оны санхүүгийн тайлангийн аудитаар нийт 2,394.4 сая төгрөгийн албан шаардлага хүргүүлсэн.

ОНХС-гийн хөрөнгөөр бий болсон зарим хөрөнгийн 13.6 хувь буюу 321.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалт, төсөл арга хэмжээг бүртгэл тайланд бүрэн тусгаагүй байна.

3.20 Аймаг, сумдын ОНХС-гийн хөрөнгөөр хийгдсэн 66 хөрөнгө оруулалт, төсөл арга хэмжээний 3,231.4 сая төгрөгийн буюу 53 нийт хөрөнгө оруулалт, төсөл, хөтөлбөр арга хэмжээний 80 хувийг бүртгэсэн байна.

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4⁵³, 14.4.2⁵⁴, 5 дугаар зүйлийн 5.1.4⁵⁵, 13 дугаар зүйлийн 13.1⁵⁶, 18 дугаар зүйлийн 18.1⁵⁷ гэж заасныг тус тус зөрчиж ОНХС-гийн хөрөнгөөр санхүүжүүлсэн төсөл хөтөлбөрийн 16.9 хувь буюу нийт

⁵³ “Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ”,

⁵⁴ “Бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлага”,

⁵⁵ “Нягтлан бодох бүртгэлд үнэн зөв байх зарчим баримтална”

⁵⁶ Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно”,

⁵⁷ “Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ”

661.9 сая төгрөгийн дараах хөрөнгө оруулалтын ажлуудыг данс бүртгэлд тусгаагүй байна. Тухайлбал:

- Аймаг 235.6 сая төгрөгийн 4 төсөл арга хэмжээ, хөрөнгө оруулалтыг
- Баян-Агт сум 0.3 сая төгрөгийн 1 төсөл арга хэмжээг
- Булган сум 18.4 сая төгрөгийн 2 төсөл, арга хэмжээг
- Бүрэгхангай сум 382.0 сая төгрөгийн 2 төсөл, арга хэмжээ, хөрөнгө оруулалтыг
- Орхон сум 19.7 сая төгрөгийн 1 төсөл, арга хэмжээг
- Хангал сум 3.4 сая төгрөгийн 1 төсөл, арга хэмжээг
- Хутаг-Өндөр сум 2.0 сая төгрөгийн 2 төсөл арга, арга хэмжээг тус тус дутуу бүртгэсэн.



3.21 Дээрх данс бүртгэлд тусгаагүй 399.0 сая төгрөгийн зөрчилд данс бүртгэлд бүртгээгүй, хяналт сулаас дутсан 5 төсөл, арга хэмжээний 9.9 сая төгрөгт төлбөрийн акт, 7 төсөл арга хэмжээний 648.1 сая төгрөгийн хөрөнгийг ашиглагч байгууллагын данс бүртгэлд тусгах албан шаардлага, хөрөнгийг данс бүртгэлд үнэн зөв тусгах зөвлөмжийг холбогдох байгууллагад хүргүүлээ.

ОНХС-гийн хөрөнгийн зарцуулалт, үр дүнгийн талаар Уирдлага мэдээллийн системд бүрэн оруулж, иргэдэд ил тод нээлттэй мэдээлээгүй байна.

3.22 Сангийн сайдын 2021 оны 86 дугаар тушаалаар баталсан “ОНХС-гийн үйл ажиллагааны журам”-ын 10 дугаар зүйлд ОНХС-гийн удирдлага мэдээллийн системд хэн, хэрхэн, хэзээ хариуцан оруулж олон нийтэд ил тод мэдээлэх талаар зааж өгсөн байна.

3.23 Булган аймгийн хэмжээнд удирдлага мэдээллийн системд оруулсан мэдээллийн хөрөнгө оруулалт, төсөл арга хэмжээний гүйцэтгэлийг мэдээлж байгаа боловч ОНХС-гийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн хөрөнгө оруулалт, төсөл арга хэмжээний талаарх мэдээллийг огт мэдээлээгүй, зарим мэдээлэл зөрүүтэй, дутуу мэдээлсэн байна. Тухайлбал:

- Нийт хөрөнгө оруулалт, төсөл хөтөлбөр, арга хэмжээний 51.4 хувь 2,124.4 сая төгрөгийн батлагдсан төсөв, санхүүжилтийн төсөв, нийт гэрээний дүн, зарцуулалт, санал өгсөн иргэдийн тоо, ажил гүйцэтгэгчийг мэдээллийг огт мэдээлээгүй. (Баян-Агт, Баяннуур, Бугат, Булган, Бүрэгхангай, Могод, Орхон, Сайхан, Хангал сум, Хялганат тосгон)
- ОНХС-гийн нийт төсөл арга хэмжээний төлөвлөлттэй холбоотой иргэдийн санал, ИНХ-аас баталсан төслүүд, ажлын хэсэг эрэмбэлсэн мэдээллийг мэдээлээгүй /аймаг, Баян-Агт, Бүрэгхангай/ дутуу мэдээлсэн. (Дашинчилэн, Могод, Сайхан, Сэлэнгэ, Хангал зэрэг) сумд байна.
- Батлагдсан төсөв, санхүүжилтийн төсөв, нийт гэрээний дүн, зарцуулалт, санал өгсөн иргэдийн тоо, ажил гүйцэтгэгчийг мэдээллийг илүү, дутуу зөрүүтэй мэдээлсэн нийт 11 сумд байна. (Хавсралт-3)

3.24 Аймаг, Сумдын ОНХС хариуцсан мэргэжилтэн ОНХС-гийн хуваарилалт, төлөвлөлт, хэрэгжилт, тайлагналт, хяналт, бүртгэлийн холбогдох мэдээллийг Удирдлага мэдээллийн системд бүрэн оруулах дээрх журмын 10.3.3⁵⁸ дахь заалтыг бүрэн хэрэгжүүлж ажиллах шаардлагатай байгаад зөвлөмж хүргүүлээ.

⁵⁸ ОНХС-ийн хуваарилалт, төлөвлөлт болон өмнөх оны хэрэгжилт, тайлан, хяналтын талаарх мэдээллийг ОНХС-ийн УМС-д зохих журмын дагуу оруулаагүй бол тухайн зөрчлийг арилгах хүртэл ОНХС, аймаг, нийслэлийн ОНХС-аас орлогын шилжүүлэг олгохгүй

Зарим сумд ОНХС-гийн хөрөнгийн зарцуулалтын талаар Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд цаг тухайд нь бүрэн мэдээлээгүй байна.

3.25 Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.2.2⁵⁹ дахь заалтад ОНХС-гийн төсөв, санхүүгийн үйл ажиллагааны төлөвлөлт, гүйцэтгэл, хэрэгжилт, тайлагнал эдгээртэй холбоотой мөнгөн болон бусад гүйлгээг 6.1.1⁶⁰-д заасан хугацаанд тогтмол мэдээлэхээр заасан байна.

3.26 Аймгийн хэмжээнд орон нутгийн хөгжлийн сангийн төлөвлөгөө, гүйцэтгэл, тендер шалгаруулалт, худалдан авах ажлын төлөвлөгөө, тухайн байгууллагын хууль тогтоомжийн дагуу төвлөрүүлэх төлбөр, хураамж, зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээнд орсон өөрчлөлт, худалдан авах ажиллагаанд хийсэн аудитын тайлан, дүгнэлт болон бусад хяналт шалгалтын дүнг мэдээлээгүй зөрчилд нийт 6 албан шаардлагыг холбогдох сумдын Засаг дарга нарт хүргүүлээ.

3.27 Мөн Санхүүгийн тайлан баталгаажуулах аудитаар Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд ОНХС-гийн зарцуулалтыг мэдээлээгүй нийт 392.9 сая төгрөгийн зөрчлийг таслан зогсоох арга хэмжээ авч ажиллах албан шаардлагыг хүрүүлсэн.

ДҮГНЭЛТ:

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, аудитын үр дүнд үндэслэж дараах дүгнэлтийг хийж байна. Үүнд:

- Аймгийн ОНХС-гаас сумдад олгох шилжүүлгийг ОНХС-гийн орлогын эх үүсвэр Сангийн яаманд хоцорч төвлөрсөнтэй холбоотойгоор сумдын ОНХС-гийн хөрөнгийг хуваарийн дагуу шилжүүлээгүй байна.
- Зарим сумд малын тоо толгойн жилийн албан татварын орлого, орон нутгийн хөгжлийн сангийн харилцах дансны эхний үлдэгдлийн ОНХС-гийн эх үүсвэрт нэмж төлөвлөөгүй байна.
- Аймаг, сумын хэмжээнд ОНХС-гийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл арга хэмжээнд сонгууль өгөх насны 27.3 хувь нь хамрагдсан нь ОНХС-гийн хөрөнгөөр хэрэгжүүлэх хөрөнгө оруулалт, төсөл, арга хэмжээнд иргэдийн саналыг авах ажил хангалтгүй, иргэдийг санал өгөх хүртээмжтэй байдлаар зохион байгуулаагүй, сургалт сурталчилгаа соён гэгээрүүлэх ажлыг үр дүн муутай зохион байгуулсантай холбоотой байна.
- Аймгийн ОНХС-гийн хөрөнгөөр хэрэгжүүлэх хөрөнгө оруулалт, төсөл арга хэмжээг орон нутгийн хөгжлийн бодлого, тэргүүлэх чиглэлтэй уялдаагүй хөтөлбөр, төсөл арга хэмжээг баталж хэрэгжүүлсэн
- Сумдын хэмжээнд ОНХС-ийн хөрөнгөөр иргэдийн санал аваагүй, зураг төсөвгүй ТЭЗҮ-гүй төсөл, арга хэмжээг баталж, хэрэгжүүлдэг зөрчил давтан гарсаар байгаа нь ОНХС-ийн хөрөнгийн үр өгөөжийг бууруулж, орон нутагт үр ашиггүй хөрөнгө нэмэгдэх эрсдэлийг нэмэгдүүлж байна.
- Аймаг, сумд нийт ОНХС-гийн хөрөнгөөр хэрэгжүүлэхээр төлөвлөсөн төсөл арга хэмжээний 67 хувь буюу 3,782.1 сая төгрөгийг иргэдийн санал аваагүй, ТЭЗҮ-гүй, шаардагдах хөрөнгө, төсөвт өртгийг тооцоогүй төсөл, арга хэмжээг баталж, хэрэгжүүлсэн байна.
- ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн нийт төсөл арга хэмжээний 21.7 хувь нь худалдан авах ажиллагааны хууль, журмыг зөрчсөн байна.

⁵⁹ Засгийн газрын тусгай сан

⁶⁰ тухайн жилийн төсөв, худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, орон нутгийн хөгжлийн сангийн төлөвлөлтийг төлөвлөлтийг жил бүрийн 01 дүгээр сарын 10-ны өдрийн дотор;

- Сумдын ОНХС-гийн хөрөнгөөр хэрэгжүүлэхээр төлөвлөсөн төсөл, арга хэмжээг 86.5 хувийг шууд худалдан авалтаар гүйцэтгэсэн байна.
- ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх боломжтой чиг үүргээс бусад төсөл, арга хэмжээнд сангийн хөрөнгийг зарцуулсан байна.
- Аймаг, сумдын хэмжээнд Тэшиг сумаас бусад ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл арга хэмжээг төлөвлөхдөө зорилтот түвшин, үр ашиг, үр дүнг бодитой тодорхойлоогүй байна.
- ОНХС-гийн хөрөнгөөр бий болсон зарим хөрөнгийн 13.6 хувь буюу 321.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалт, төсөл арга хэмжээг бүртгэл тайланд бүрэн тусгаагүй байна.
- Сумдын хувьд ОНХС-гийн хөрөнгийг орон нутгийн хөгжил эдийн засгийн ач холбогдол бүхий хөрөнгө оруулалтад бус, богино хугацааны хэрэгцээ, шаардлага хангах, олон жижиг арга хэмжээ буюу нийгмийн үр ашигтай байдал талаасаа учир дутагдалтай төсөл, арга хэмжээнд зарцуулж байна.
- Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийн төлөвлөлт, хэрэгжилтэд тавих бүх шатны ИТХ-ын хяналт хангалтгүй, Санхүүгийн хяналт, дотоод аудитын алба аймгийн ОНХС-гийн хэрэгжилтэд тусгайлан хяналт шалгалт хийдэггүйгээс зарим хэрэгжүүлэхээр төлөвлөсөн төсөл арга хэмжээний ашиглалт хамгаалалт хангалтгүй төсвийн хөрөнгийг үр ашиггүй зарцуулах эрсдэл үүсж байна.
- Сумдын түвшинд захиалагчийн хяналтыг хууль, журмын дагуу бүрэн хэрэгжүүлж ажиллаагүй байна.
- Сумдын Засаг даргын Тамгын газар ОНХС-гийн хөрөнгөөр санхүүжиж буй хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний хэрэгжилтийн тайланд шинээр бий болсон барилга байгууламж, гүйцэтгэсэн их засварын ажил, нийлүүлэгдсэн тоног төхөөрөмжийг өмчлөлд бүртгэснийг баталгаажуулсан баримт, сайн туршлага, жишээ оновчтой санал зэргийг тусгаагүй байна.
- Зарим сумд ОНХС-гийн удирдлага мэдээллийн системд холбогдох мэдээллийг огт оруулаагүй, ОНХС-гийн хөрөнгийн төлөвлөлт, зарцуулалтын мэдээллийг иргэдэд ил тод нээлттэй танилцах боломжоор хангаагүй, мөн шилэн дансны цахим хуудсанд цаг тухайд нь бүрэн мэдээлээгүй байна.

-оОо-

ЗӨВЛӨМЖ:

Аудитын дүн, дүгнэлтэд үндэслэн дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг зөвлөж байна.

Аймгийн Иргэдийн төлөөлөгчийн хурлын дарга Д.Эрдэнэбат танаа

1. Аймгийн орон нутгийн сангийн төлөвлөлт, зарцуулалтад холбогдох хууль, журамд заасан хяналт шалгалтын ажлын чиг үүргээ хэрэгжүүлэн ажиллах.

Булган аймгийн Засаг дарга Б.Ариун-Эрдэнэ танаа:

1. ОНХС-гийн эх үүсвэрийг нэмэгдүүлэх, ОНХС-гийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл арга хэмжээг төлөвлөх, хэрэгжүүлсэн тасал арга хэмжээний ашиглалт, хамгаалалт, хадгалалтад, зарцуулалтад давхар хяналт тавихад иргэдийн оролцоог нэмэгдүүлэх, иргэдээс гарсан саналыг орон нутгийн хөгжлийн бодлого болон бусад хууль тогтоомжид заасан шалгуур нөхцөлтэй уялдуулан төсөл арга хэмжээний зорилтод түвшин, үр ашиг, үр дүнг бодитоор төлөвлөж, хэрэгжилтийг нь тооцож, жилийн гүйцэтгэлийн үнэлгээтэй уялдуулан дүгнэж байх.
2. ОНХС-гийн хөрөнгийн зарцуулалтад тавих хяналтыг сайжруулах арга хэмжээ авч, холбогдох хууль тогтоомжид заасан хяналт, шалгалт, дүгнэлт гаргах захиргааны байгууллагуудаар хяналтын чиг үүргийг нь хэрэгжүүлэх.

Орон нутгийн өмчийн газрын дарга Т.Баттулга танаа:

1. ОНХС-гийн хөрөнгөөр хэрэгжүүлэх хөрөнгө оруулалт, арга хэмжээний худалдан авах ажиллагааг зохион байгуулахдаа дотоод хяналт шалгалтыг сайжруулах.

Сумдын ИТХ-ын дарга нарт:

1. ОНХС-гаас хэрэгжүүлж буй төсөл, арга хэмжээнд тавих хяналтыг тогтмолжуулж, холбогдох байгууллагад өгсөн чиглэл, үүргийн биелэлтийг тооцох

Сумдын Засаг дарга нарт:

1. Иргэдийн саналыг эрэмбэлэхдээ Сангийн сайдын 2021 оны 86 дугаар журмын 6.1, 6.3, 6.4-д заасныг бүрэн хэрэгжүүлж ажиллах /1.2.1/
2. Орон нутгийн хөгжлийн сангийн сарын хуваарийг баталж хэвших
3. ОНХС-гийн хөрөнгөөр санхүүжүүлсэн төсөл, арга хэмжээний үр дүнд бий болсон өмчлөлтэй холбоотой асуудал болон хөрөнгийн ашиглалтын урсгал зардлыг тооцох, орон нутгийн төсөвт нөлөөлөх нөлөөллийн талаарх дүгнэлтийг гаргах, төсөл, арга хэмжээний үр дүнг тодорхойлж хэвших.
4. ОНХС-гийн хөрөнгийн төлөвлөлт, зарцуулалтыг мэдээллийг удирдлага мэдээллийн системд мэдээллийг бүрэн мэдээлж байх.
5. Төрийн болон орон нутгийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн холбогдох заалтыг хэрэгжүүлж ажиллах.
6. ОНХС-гийн хөрөнгөөр гүйцэтгэсэн ажилд гэрээнд заасан хугацаанд гүйцэтгэгчээс, ажлын хэсгийг түргэн шуурхай томилж төсөл, арга хэмжээг хүлээж авах.
7. Хөрөнгийг бүртгэл тайланд тусгахдаа үнэн зөв дүнгээр орлого авч тайлагнах.

-оОо-

Орон нутгийн хөгжлийн сангийн санхүүжилтийн хуваарь, санхүүжилтийн гүйцэтгэл

Д/д	Сумдын нэрс	2		3		4		5		6		7		8		9		10		11		12		Нийт дүн	
		Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	Баян-агт			0.0	0.0	5.0	0.0	24.3	5.0	5.0	5.0	5.0	29.3	0.0	0.0	5.0	5.0	13.5	13.5	15.0	15.0	8.5	8.5	81.3	81.3
2	Баяннуур			5.0	0.0	5.0	5.0	2.9	7.0	2.0	2.0	5.0	5.9	0.0	0.0	0.0	0.0	6.8	6.8	0.0	0.0	6.7	6.7	33.4	33.4
3	Бугат			5.0	0.0	5.0	5.0	3.3	5.0	2.0	2.0	5.0	8.3	0.0	0.0	0.0	0.0	7.1	7.1	5.0	5.0	5.6	5.6	38.0	38.0
4	Булган			0.0	0.0	18.0	10.0	6.9	10.0	10.0	10.0	5.0	9.9	0.0	0.0	5.0	5.0	19.5	19.5	10.0	10.0	6.0	6.0	80.4	80.4
5	Бүрэгхангай			20.0	0.0	30.0	0.0	4.3	30.0	20.0	15.0		24.3	5.0	5.0	15.0	15.0	17.8	37.8	20.0	20.0	14.0	14.0	161.1	161.1
6	Гурванбулаг			0.0	0.0	10.0	5.0	22.8	5.0	0.0	0.0	5.0	27.8	0.0	0.0	5.0	5.0	13.3	13.3	10.0	10.0	12.8	12.8	78.9	78.9
7	Дашинчилэн			5.0	0.0	10.0	5.0	4.7	11.7	5.0	5.0	5.0	8.0	0.0	0.0	5.0	5.0	13.1	13.1	5.0	5.0	7.2	7.2	60.0	60.0
8	Могод			5.0	0.0	5.0	5.0	4.4	5.0	5.0	5.0	5.0	5.0	0.0	4.4	5.0	5.0	7.8	7.8	5.0	5.0	7.3	7.3	49.4	49.4
9	Орхон			20.0	0.0	25.0	10.0	4.5	20.0	20.0	15.0	15.0	24.5	10.0	10.0	15.0	15.0	22.9	37.9	20.0	20.0	18.8	18.8	171.2	171.2
14	Хангал			5.0	0.0	0.0	0.0	12.8	5.0	0.0	0.0	5.0	17.8	0.0	5.0	5.0	0.0	6.8	6.8	3.0	3.0	3.8	3.8	41.3	41.3
11	Сайхан			5.0	0.0	10.0	5.0	4.6	7.0	10.0	10.0	5.0	12.6	0.0	0.0	5.0	5.0	8.2	8.2	5.0	5.0	11.5	11.5	64.3	64.3
12	Сэлэнгэ			10.0	0.0	10.0	8.0	6.4	8.0	10.0	10.0	5.0	15.4	0.0	0.0	5.0	5.0	14.0	14.0	10.0	10.0	12.9	12.9	83.2	83.2
13	Тэшиг			5.0	0.0	25.0	10.0	9.6	12.0	10.0	10.0	5.0	22.6	5.0	5.0	15.0	15.0	21.2	21.2	10.0	10.0	17.1	17.1	122.9	122.9
14	Рашаант			0.0	0.0	10.0	5.0	23.5	3.0	0.0	0.0	5.0	30.5	5.0	5.0	5.0	5.0	13.4	13.4	5.0	5.0	15.2	15.2	82.0	82.0
15	Хишиг-Өндөр			5.0	0.0	10.0	0.0	3.9	0.0	2.0	0.0	5.0	8.0	0.0	0.0	5.0	5.0	10.5	10.5	0.0	0.0	8.1	8.1	49.4	49.4
16	Хутаг-Өндөр			5.0	0.0	20.0	10.0	8.4	8.0	5.0	5.0	5.0	20.4	5.0	5.0	10.0	10.0	15.6	15.6	15.0	15.0	10.6	10.6	99.6	99.6
17	Хялганат			5.0	0.0	0.0	0.0	12.8	5.0	0.0	0.0	5.0	17.8	0.0	0.0	5.0	5.0	6.8	6.8	3.0	3.0	3.8	3.8	41.3	41.3
	Сумдын дүн	0.0	0.0	100.0	0.0	198.0	83.0	159.9	146.7	106.0	94.0	90.0	288.0	30.0	39.4	110.0	105.0	218.1	253.1	141.0	141.0	169.7	169.7	1,337.8	1,337.8
18	Аймаг	133.2	83.3	133.3	167.5	204.9	259.6	300.1	424.9	77.3	276.3	296.1	276.3	321.5	551.8	372.2	696.7	225.2	116.1	183.0	530.7	125.3	701.1	2,372.1	4,084.3

Хавсралт-2

Орон нутгийн хөгжлийн сангийн санал асуулгын нэгтгэл

№	Санал асуулга	Үзүлэлт	Дүн	Эзлэх хувь
1	Санал, асуулгад оролцсон иргэдийн тоо		560	
		Баян-Агт	8	1.4
		Баяннуур	14	2.5
		Бугат	38	6.8
		Булган	187	33.4
		Бүрэгхангай	1	0.2
		Гурванбулаг	3	0.5
		Дашинчилэн	46	8.2
		Могод	21	3.8
2	Таны амьдарч буй сум, дүүргийн нэр	Орхон	14	2.5
		Рашаант	1	0.2
		Сайхан	9	1.6
		Сэлэнгэ	91	16.3
		Тэшиг	37	6.6
		Хангал	6	1.1
		Хишиг-Өндөр	20	3.6
		Хутаг-Өндөр	32	5.7
		Хялганат	29	5.2
3	Таны нас	16-25	39	7
		26-35	207	37
		36-50	236	42.1
		51-ээс дээш	67	12
		Бакалавр	439	78.4
4	Таны боловсрол	Бүрэн бус дунд	1	0.2
		Бүрэн дунд	1	0.2
		Бүрэн бус дунд	2	0.4
		Бүрэн дунд	93	16.6
		Магистр	4	0.7
		Мастер	1	0.2
		Тусгай дунд	12	2.1
5	Орон нутгийн хөгжлийн сангийн талаар хэр мэдээлэлтэй вэ?	Хангалтгүй	351	62.7
		Хангалттай сайн	197	35.2
6	Орон нутгийн хөгжлийн сангийн талаарх мэдээллийг хаанаас авдаг вэ?	Засаг дарга, хороодын хэсгийн ахлагч	112	20
		Орон нутгийн мэдээллийн самбар, радио, телевиз, сошиал, фейсбүүк	187	33.4
		Нэг цэгийн үйлчилгээ, иргэний танхимын ажилтан	16	2.9
		Удирдлагын мэдээллийн системээс	39	7
		Мэдээлэл авдаггүй	194	34.6
7	Орон нутгийн хөгжлийн сангийн "Удирдлагын мэдээллийн системээс ямар төрлийн мэдээлэл авдаг вэ?	Сангийн хөрөнгийн төлөвлөлттэй холбоотой	62	11.1
		Тендер сонгон шалгаруулалттай холбоотой	57	10.2
		Төсөл, арга хэмжээний гүйцэтгэл, биелэлттэй холбоотой	108	19.3

		Сангийн хөрөнгийн тайлан, мэдээтэй холбоотой	43	7.7
		Мэдээлэл авдаггүй.	273	48.8
8	Та Орон нутгийн хөгжлийн сангийн талаарх холбогдох хууль, тогтоомж, журам, зааврыг судалж үзсэн үү?	Үгүй	357	63.8
		Тийм	190	33.9
9	Таны баг, хорооны Засаг дарга Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хамгийн түрүүнд хийх шаардлагатай ажлуудын саналыг иргэдээс авах ажлыг зохион байгуулдаг уу?	Тийм	232	41.4
		Үгүй	117	20.9
		Сайн мэдэхгүй	198	35.4
10	Та энэ үйл ажиллагаанд оролцож саналаа өгсөн үү?	Тийм	253	45.2
		Үгүй	291	52
11	Засаг дарга ийнхүү авсан саналыг эрэмбэлж, хамгийн их санал авсан ажлуудыг иргэдэд танилцуулж, нээлттэй хэлэлцүүлэг хийсэн үү?	Тийм	168	30
		Үгүй	125	22.3
		Сайн мэдэхгүй	251	44.8
12	Та орон нутагтаа тус сангийн хөрөнгөөр хийгдэж буй бүтээн байгуулалтын ажлууд бодитой хэрэгжиж байгаа эсэхэд хяналт тавьдаг уу?	Тийм	178	31.8
		Үгүй	367	65.5
13	Та орон нутагтаа тус сангийн хөрөнгөөр хийгдэж буй бүтээн байгуулалтын ажлуудад хэр сэтгэл хангалуун байдаг вэ?	Хангалттай сайн	153	27.3
		Хангалтгүй	207	37
		Мэдэхгүй	189	33.8
		Сайн	91	16.3
14	2021 онд ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээний үр дүнд бий болсон хөрөнгийн ашиглалт ямар байна вэ?	Дунд	162	28.9
		Хангалтгүй	92	16.4
		Мэдэхгүй	202	36.1
15	2021 онд ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн төсөл арга хэмжээний хадгалалт, хамгаалалт зохих түвшинд байна уу?	Хангалттай	121	21.6
		Хангалтгүй	165	29.5
		Мэдэхгүй	263	47

-oOo-

Удирдлага мэдээллийн системийн мэдээлэл

Д/д	Аймаг, сумдын нэрс	Хэрэгжүүлэхээр төлөвлөсөн төсөл, хөтөлбөр, арга хэмжээний		Удирдлага мэдээллийн системд мэдээлээгүй төсөл, хөтөлбөр, арга хэмжээний				Удирдлага мэдээллийн системд мэдээлээгүй				Удирдлага мэдээллийн системд алдаатай /+илүү, -дутуу/ мэдээлэл					
		тоо	Мөнгөн дүн	тоо	Мөнгөн дүн /зарцуулалт/	Хувь /тоо/	Хувь /мөнгөн дүн/	Иргэдийн санал	ИНХ-аас баталсан төслүүд	Ажлын хэсэг эрэмбэлсэн	ИТХ-аас баталсан төслүүд	Батлагдсан төсөв	Санхүүжилт	Нийт гэрээний дүн	Зарцуулалт	Санал өгсөн иргэдийн тоо	Гүйцэтгэгчид
1	2	3		4				5				6					
1	Булган аймаг	18	2,906.40	16	2906.4	88.9	100	3	3	3	1	-	-	-	-	-	-
2	Баян-Агт сум	16	81.9	15	72.4	93.8	88.4	3	3	3	1	145.1	75.9	6.5	(35.7)	3,016	(4)
3	Баяннуур сум	9	61.5	1	4	11.1	6.5	1	1	2	1	-	31.5	-	-	-	-
4	Бугат сум	10	98.4	10	98.4	100	100	3	3	3	3	-	-	-	-	-	-
5	Булган сум	10	111.1	10	111.1	100	100	3	3	3	3	-	-	-	-	-	-
6	Бүрэгхангай сум	10	1,390.10	10	1390.1	100	100	3	3	3	3	1,390.10	1,560.80	646.7	570.7	2,270	23
7	Гурванбулаг сум	4	143.6	0	0	0	0	1	1	1	1	-	143.6	-	-	-	-
8	Дашинчилэн сум	12	106.1	0	0	0	0	2	2	2	0	(92.1)	(106.1)	(80.3)	(80.3)	5,350	(9)
9	Могод сум	12	102	12	102	100	100	2	1	1	1	(98)	(112.9)	(44)	(44)	863	(5)
10	Орхон сум	14	224.2	14	224.2	100	100	3	3	3	3	-	-	-	-	-	-
11	Рашаант сум	15	207.7	0	0	0	0	1	1	1	1	-	207.7	-	-	-	-
12	Сайхан сум	8	83.7	6	53.8	75	64.3	2	2	2	0	(62.7)	-	(21.9)	(21.9)	1,886	(4)
13	Сэлэнгэ сум	9	83.2	0	0	0	0	2	2	2	0	(51.2)	-	(18.2)	(45.2)	2,682	1
14	Тэшиг сум	4	226.8	0	0	0	0	1	1	1	1	(82.7)	83.5	129.5	128.5	2,909	73
15	Хангал сум	6	52.5	4	27.1	66.7	51.6	2	1	1	1	(26.5)	(2)	(21)	(29)	862	(4)
16	Хишиг-Өндөр сум	7	63.1	0	0	0	0	1	1	1	1	-	-	-	-	-	-
17	Хутаг-Өндөр сум	4	99.6	0	0	0	0	1	1	1	1	-	-	-	-	-	-
18	Хялганат тосгон	7	41.3	7	41.3	100	100	3	3	3	3	-	-	-	-	-	-
	Нийт дүн	175	6,083.20	105	5030.8							1,122.00	1,882.00	597.3	443.1	19,838	71

Жич: Хүснэгтийн мэдээллийн тэмдэглэгээ.

Багана 5

Бүрэн мэдээлсэн	1
Мэдээлэл дутуу	2
Мэдээлээгүй	3

Багана 6:

Батлагдсан төсөв	УМС дээрх батлагдсан төсөв, ИТХ-аас анх баталсан төсвийн ялгавар
Санхүүжилт	УМС дээрх санхүүжилт, ИТХ-аар баталсан санхүүжилтийн ялгавар
Нийт гэрээний дүн	УМС дээрх нийт гэрээний дүн, гүйцэтгэлээр гэрээний дүнгийн ялгавар
Зарцуулалт	УМС дээрх зарцуулалт, гүйцэтгэлээр зарцуулалтын ялгавар
Санал өгсөн иргэдийн тоо	УМС дээрх санал өгсөн иргэд, иргэдийн саналын ялгавар
Гүйцэтгэгчид	УМС дээрх гүйцэтгэгчдийн тоо, гүйцэтгэлээр гүйцэтгэгчийн тооны ялгавар

-oOo-